



2025 оны 04 дүгээр сарын 10  
№15 (1360)

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
АЛБАН МЭДЭЭЛЭЛ



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

71. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр соёрхон батлах тухай 727

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

72. Үндсэн хуулийн цэцийн 2025 оны  
01 дүгээр дүгнэлтийн тухай Дугаар 31 729
73. Үндсэн хуулийн цэцийн 2025 оны  
03 дугаар дүгнэлтийн тухай Дугаар 32 731

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

74. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 01 733
75. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 03 763

### МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

76. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр 795

۲۷۰



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны 03 дугаар  
сарын 27-ны өдөр

Улаанбаатар  
хот

ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН  
ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ, НҮҮРСНИЙ  
ХУДАЛДАА, ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН  
ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХАМТЫН  
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР  
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

۲۰۰۸ء میں ۳۵٪ تک پہنچا۔

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

ପ୍ରାଚୀ

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 31

Улаанбаатар  
 хот

### Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшиүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүний ... үзэл бодол ...-оор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

۳۰ میں ۹:۳۰ صبح ۲۵ فروری ۲۰۱۷ء کو پاکستانی سفیر احمد علی خان نے اسلام آباد میں اپنے سفارتی محلہ پر بھائیوں کی طرف سے دعویٰ کی تھی۔

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ  
الْكِتَابُ عِزِيزٌ وَالرَّحْمَةُ وَاسِعَةٌ  
وَلَا يَنْهَا كُلُّ نَفْسٍ عَنِ الْمُحِيطِ  
إِنَّ اللَّهَ لَذُوقَهُ مَنْ شَاءَ مِنْ أَهْلِ  
الْأَرْضِ وَمَنْ يَنْهَا فَأُولَئِكَ هُمُ الظَّالِمُونَ

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

ପ୍ରାଚୀ



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 32

Улаанбаатар  
 хот

### Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН

بیشترین شکاف دارایی را در این سال می‌گذراند.

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ  
فَاتَّحُوا الْبَلَدَ فَمَا أَنْتُمْ بِهِ مُكَفِّرُونَ  
وَمَا أَنْتُمْ بِأَنْفُسِكُمْ تَعْلَمُونَ

بِسْمِ اللَّهِ الرَّحْمَنِ الرَّحِيمِ

၁၃၁



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 01 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
 хот

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай  
хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг  
Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх  
маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 16.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан /илтгэгч/, Ц.Цолモン, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Д.Алтангэрэл болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдуугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Монгол Улсын иргэн Д.Алтангэрэл Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий өргөдөл, голмолов ирүүлжээ:**

“Миний бие Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр холбогдох баримтуудыг бүрдүүлэн Сонгуулийн ерөнхий хороонд өгсөн юм. Гэвч Сонгуулийн ерөнхий хороо 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 158 дугаар тогтоолоороо Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасныг үндэслэн нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзжээ. Үүнийг миний бие дараах үндэслэлээр хүлээн зөвшөөрөхгүй байна.

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшигчээр нь Сонгуулийн

ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэсэн нь хоёр алдаатай гэж үзэж байна. Нэгдүгээрт энэхүү “... дэвшиүүлэгч ...” зүйлийн эзэн нь бусад сонгогчдоосоо 801-ээс доошгүй гарын үсэг зуруулах шаардлагатай мэтээр заасан нь нэг мөр ойлгох боломжгүй, зүйлийн эзнийг буюу биеийн төлөөний угзэ буруу тодорхойлсон монгол хэлний найруулга зүйн алдаатай; хоёрдугаарт Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад иргэний бүртгэлийн дугаарыг заавал бүртгэнэ гэх зөвлөмж өгсөн. Миний мэдсэнээр регистрийн дугаарт иргэний гэрийн хаяг, холбоо барих дугаар багтдаг бол иргэний бүртгэлийн давтагдашгүй арван хоёр оронтой дугаарт тухайн хүний хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, татварын мэдээлэл зэрэг хувийн нууцад хамаарах мэдээлэл агуулагддаг байна. Сонгуулийн ерөнхий хорооны баталсан маягт нь Хувь хүний нууцын тухай хуулийг зөрчсөн, хуулиас давсан илт хууль бус үйл ажиллагааг шаардсан журам болсон учраас Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг хууль бус юм.

2.Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн тэгш эрхийн зарчим нь адилтгаж болох буюу эрх зүйн байдал нь ижил этгээдүүдийн хувьд авч үздэг ойлголт тул миний бие намын гишүүн биш учраас тэгш эрхийн зарчим үйлчлэхгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлэгт заасан хүний эрх, эрх чөлөө нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал бөгөөд хүний үндсэн эрхийг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан. Энэхүү бүлгийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” хэмээн заасан. Миний бие энэ эрхээ баталгаатай эдэлмээр байна. Иргэд Үндсэн хуулиар хамгаалагдан баталгаажуулсан эрхээ эдлэх гэж заавал 801-ээс доошгүй иргэний гарын үсэг цуглуулах ёстой байхад намын гишүүд дээрх гарын үсгийг цуглуулахгүй намын сонголтоор шууд нэр дэвших эрхээ эдэлж байгаа нь тэгш эрхийн зарчимд нийцэхгүй байна. Нам бол төрийн бус байгууллага. Бид бүгд Монгол Улсын иргэний хувьд ижилхэн эрхтэй, тэд Үндсэн хуульд заасан дээрх эрхээ шууд эдэлж байхад, иргэн миний бие яагаад уг эрхээ эдлэх боломжгүй, ялгаварлагдан гарын үсэг цуглуулах үүрэгтэйг огт ойлгохгүй байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлд заасан үүргүүдэд энэ тухай огт заагаагүй. Иймд миний бие Үндсэн хуульд заасан эрхээ эдэлж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцмоор байна.

Иймээс Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан



гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчиж байгаа учир Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн үйлчлэлийг яаралтай хүчингүй болгож өгнө үү.” гэсэн байна.

**Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:**

“... Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэж заасан нь хууль батлах, төлөөллийн дээд байгууллагын гишүүн болох нэгэн гол шалгуур бол тухайн тойргийн сонгочийн төлөөллийг оролцуулах, Улсын Их Хурлын гишүүн ард түмний элч байхын тулд ард түмнээс сонгогчдоосоо дэмжлэг авах, иргэнийхээ төлөө байдагт оршино.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтад “хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;” гэж Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг заасан нь хуулийн хүрээнд, хуульд заасан үндэслэлээр үл ялгаварласан, хуулийн өмнө тэгш байх зарчмын хүрээнд хүний эрхийг дээдэлсэн Монгол Улсад дагаж мөрдөх хуулийг баталж байна. Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. ...” гэж хуульчилсан. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар бие даан нэр дэвших иргэн болон улс төрийн нам, эвслээс сонгуульд оролцоход тодорхой шалгуурыг тогтоосон билээ.

Улс төрийн нам, эвслийн тухайд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлд зааснаар сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ сонгуульд оролцох хүсэлтэд нам, эвслийн дарга гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ даран баталгаажулахаар хүсэлтээ илэрхийлж, эвслийн тухайд эвсэлд нэгдэн орсон бүх намууд тамга /тэмдэг/ даран баталгаажуулна.

Мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргахаар тусгасан бөгөөд үүнд сонгуульд оролцох тухай намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллагын шийдвэр; намын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар; энэ хуульд нийцсэн нэр дэвшиүүлэх ажиллагааны талаарх намын дотоод журам; намын сонгууль эрхэлсэн байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, хаяг, харилцах утасны дугаар, цахим шуудангийн хаяг, ажиллах хүний too зэргийг нарийвчлан хуулиар зохицуулжээ. Түүнчлэн Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.6 дахь заалтад улс төрийн намыг бүртгүүлэх өргөдөлд “намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл ...”-ийг хавсаргахаар зохицуулжээ.

Иргэний хувьд сонгуульд нэр дэвшихэд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн болон улс төрийн нам, эвслээс сонгуульд оролцохоо илэрхийлэхдээ тодорхой, дээрх шалгуурыг тогтоосон нь зүйд нийцэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

**Гурав. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос 2024 оны 1/819 дугаар албан бичгээр Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар, лавлагаанд:**

“ ... 1.Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг нийт 9 удаа зохион байгуулахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (Сонгуулийн тухай хууль)-ийн 5 удаагийн шинэчилсэн найруулга батлагдаж эрх зүйн орчин тодорхой хэмжээнд өөрчлөгдж байсан. Эдгээр хууль эрх зүйн орчны өөрчлөлтөөр бие даан нэр дэвших бол тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны дэмжилэг буюу дэмжигч сонгогчийн гарын үсэг зуруулах талаарх зохицуулалтад ямар нэгэн өөрчлөлт орж байгаагүй. ... Нам, эвслээс нэр дэвшүүлэх ажиллагааг тухайн нам, эвслийн төлөөллийн төв байгууллага нь нууц санал хураалтаар шийдвэрлэдэг бол бие даан нэр дэвшүүлэх ажиллагааны онцлог нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлагыг хангаж буй иргэн тухайн нэр дэвших гэж буй тойргийн сонгогчдоос дэмжилэг авснаар бие даан нэрээ дэвшүүлэх эрх нь үүсдэг. Мөн сонгуульд оролцож буй нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөр боловсруулж, түүнийг төрийн аудитын байгууллагад хянуулж, дүгнэлт гаргуулдаг бол бие даан нэрээ дэвшүүлэгч нь мөн адил мөрийн хөтөлбөр боловсруулж, хэрэв сонгогдох юм бол бүрэн эрхийн хугацаандaa түүнийг хэрэгжүүлэх үндсэн баримт бичиг болдог бөгөөд бие даан нэр дэвшигч нь парламентад суудал бүхий нам, эвслийн нэгэн адил хууль тогтоох байгууллагын бүрдүүлэгч болдог тул нам, эвслийг анх байгуулахад тавигдах шаардлагатай адилтган хууль тогтоогч үздэг байх боломжтой юм.

1992 оноос хойш зохион байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын 9 удаагийн ээлжит сонгуулийн хугацаанд тухайн үед мөрдөгдөж байсан



хууль тогтоомжийн дагуу бие даан нэрээ дэвшүүлэгч 801-ээс дээш тооны гарын үсэг зуруулсан байх шаардлага хангаагүй үндэслэлээр 2016 онд 3, 2020 онд 14, 2024 онд 4 бие даан нэрээ дэвшүүлэгчийг бүртгэхээс татгалзсан байна. ...

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт бие даан нэрээ дэвшүүлэгчээс сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад бичигдэх мэдээллийг тодорхойлсон бөгөөд үүнд сонгочийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаар зэргийг тодорхой бичсэн байхаар хуульчилсан. Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн "Маягт батлах тухай" 19 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан гарын үсэг зуруулах маягтыг батлахдаа хуульд заасан дээрх мэдээлэл бүрийг үндэслэл болгосон болно.

3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн 8 дугаар тойрот бие даан нэрээ дэвшүүлсэн Дугаржавын Алтангэрэл нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасан 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулах шаардлага хангаагүй тул тус Хорооны 2024 оны 158 дугаар тогтоолоор бие даан нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан болно. Бие даан нэрээ дэвшүүлэгч Д.Алтангэрэл нь нийт 715 дэмжигч сонгочийн гарын үсэг зуруулсан маягтыг тус Хороонд ирүүлсэн болно. ...

2022 оны 6 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, түүний дагалдах хуулиар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох зүйл, хэсэг, заалтад өөрчлөлт оруулж уг хуульд "регистрийн дугаар" гэснийг "иргэний бүртгэлийн дугаар" болгон өөрчилсөн. Тус Хорооны хувьд бие даан нэрээ дэвшүүлэгч нь гарын үсэг зуруулах маягтад регистрийн дугаар, эсхүл иргэний бүртгэлийн дугаар алийг нь ч бичсэн тооцно. Учир нь регистрийн дугаар, эсхүл иргэний бүртгэлийн дугаар нь гагцхүү тухайн гарын үсэг зуруулсан дэмжигч сонгогч нь бие даан нэрээ дэвшүүлэгчийн тойргийн нутаг дэвсгэрт буюу тухайн тойргийн сонгогч мөн эсэх мэдээллийг нягтлан шалгахад шаардлагатай мэдээлэл юм." гэсэн байна.

**Дөрөв. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны явцад** өргөдөл гаргагч иргэн Д.Алтангэрэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг; мөн маргаан үүсгэсэн тус хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3, Арван есдүгээр 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн

холбогдох заалтыг зөрчсөн эсэхийг тогтоолгооор өргөдлийн шаардлагаа нэмэгдүүлж, тайлбар хийсэн болно.

**Тав. Өргөдөл, гомдолыг урьдчилан шалгах болон Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх хүрээнд дараах баримт бичиг, шийдвэр, судалгаа, эх сурвалжтай танилцаж, холбогдох эрх бүхий этгээдээс баримт, тайлбар, лавлагааг гаргуулан авсан болно:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр (Цэцийн магадлал, дүгнэлт, тогтоол, Цэцийн гишүүний тогтоол);

Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны тогтоол, 2020.06.23, №244, №245;

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, 2020.06.08, №221/ШШ2020/0009;

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр, 2020.06.09, №0010;

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, “Тайлбар, лавлагаа хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.08.30, №1/819;

Улсын буртгэлийн ерөнхий газар, “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.10.25, №1/13335;

Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбар: Төрийг удирдах хэрэгт оролцох эрх, сонгох эрх, төрийн алба хаших тэгш боломжтой байх эрх, 1996, №25, CCPR/C/GC/25;

НҮБ-ын Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбар: Үл ялгаварлан гадуурхал, 1989, №18, CCPR/C/GC/18;

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газар (цаашид “ЕАБХАБ/АИХЭГ” гэх), Сонгуулийн эрх зүйн орчныг хянах удирдамж, 2013;

ЕАБХАБ/АИХЭГ-ас томилогдсон Олон улсын сонгуулийг ажиглах хороо, Монгол Улс: Парламентын сонгууль Урьдчилсан үр дүн, дүгнэлтийн талаарх мэдэгдэл, 2024.06.28;

Венецийн комисс, Сонгуулийн асуудлаарх сайн туршлагын дүрэм, CDL-AD (2002) 23;

Венецийн комисс болон ЕАБХАБ/АИХЭГ, Улс төрийн намын зохицуулалтын удирдамж, CDL-AD (2010) 024;

Венецийн комисс, Намыг парламентад оруулахыг хязгаарлах сонгуулийн тогтолцооны босго, бусад онцлогийн тухай тайлан (II), CDL-AD (2010) 007;

Венецийн комисс, Беларусь Улсын Сонгуулийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, CDL (99) 66;

Венецийн комисс, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Парламентын сонгуулийн тухай хуулийн төсөлд өгсөн санал, CDL-INF (2000) 17;



Европын зөвлөл, Ардчилсан сонгууль: Орон нутгийн болон бүсийн сонгуульд бие даан нэр дэвшигч болон сөрөг хүчний нөхцөл байдал, 2022; Хүний эрхийн Европын шүүх, Азербайжаны эсрэг Тахиров, 2015, 31953/11;

Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх, Ерөнхийлөгчийн эсрэг Өмнөд Африкийн нэг хөдөлгөөн АББ, Case CCT 158/23;

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төв, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн зохицуулалтад холбогдох гадаад орны харьцуулсан судалгаа, 2024.10.02.

### ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Их Хурал (цаашид “Улсын Их Хурал” гэх)-аас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн Зургадугаар бүлэгт Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг бүртгэх талаар зохицуулж, энэ хүрээнд бие даан нэр дэвшүүлэхэд тавих шаардлага, холбогдох журмыг хуульчилжээ. Тус хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.”, 31.3 дахь хэсэгт “Аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтыг тэмдэг дарж баталгаажуулан бие даан нэр дэвшүүлэгчид энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа явагдаж эхэлсэн өдрөөс олгоно.”, 31.4 дэх хэсэгт “Сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-ийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ... -оор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчсөн эсэх маргааныг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (цаашид “Үндсэн хуулийн цэц” гэх)-ийн дунд суудлын хуралдаанаар хянан хэлэлцэхэд дараах үндэслэл тогтоогдож байна:

Нэг. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдо заалтыг зөрчсөн эсэх

Сонгох эрх нь Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн эсхүл орон нутгийн хурлын сонгуульд саналаа өгөх эрх юм. Тухайлбал, Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалт, Хорин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар Улсын Их Хурлын гишүүнийг иргэд нийтээрээ, чөлөөтэй, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргах зарчмын дагуу сонгоно. Харин сонгогдох эрх нь төрийн эрх барих дээд байгууллага зэрэгт иргэдийг төлөөлж ажиллах бүрэн эрхийг нийт сонгогчийн саналаар олж авахад чиглэгдэнэ. Сонгогдох эрхийг баталгаатай эдлүүлэх нь сонгоч нэр дэвшигчдээс чөлөөтэй сонгох нөхцөлийг бүрдүүлнэ. Тухайлбал, Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.” гэж Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг заажээ. Намын гишүүн эсхүл гишүүн бус иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрх, боломжтой бөгөөд уг эрхээ нам, эвслээс эсхүл бие даан нэрээ дэвшүүлэх замаар хэрэгжүүлнэ.

Түүхчлэн авч үзвэл, 1992, 2005, 2011, 2015, 2019 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай холбогдох хуульд тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг зуруулах шаардлагыг тусгаж ирсэн байна. Тодруулбал, 1992 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн дэмжлэг авсан нөхцөлд Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.”, 2005 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Монгол Улсын сонгогдох эрх бүхий иргэн тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн дэмжлэг авсан нөхцөлд Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.”, 2011 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 6.2-т заасан иргэн сонгуулийн нэг тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн дэмжлэг авсан нөхцөлд тухайн сонгуулийн тойротг Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.” гэж заасан байсан бол 2015 оны Сонгуулийн тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2 дахь хэсэгт “Бие даан нэрээ дэвшүүлэгч тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй сонгогчдын гарын үсгийг сонгуулийн төв байгууллагаас баталсан маягтын дагуу зуруулна.” гэж зохицуулж, улмаар адил агуулгыг 2019 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт тусгажээ.

Монгол Улсад туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлаж болох ч уул хязгаарлалт нь эрх зүйн тодорхой байдлыг хангах, тохирсон байх, ялгаварлан гадуурхаагүй байх зэрэг нөхцөлийг хангахыг Үндсэн



хуулиар шаардах бөгөөд аль нэг нөхцөлийг нь хангаагүй бол тухайн хязгаарлалт үндсэн эрхийг зөрчсөн үндэслэл болно (Цэцийн дүгнэлт, 2017, №07; 2023, №03; 2024, №02; №03; №04; Цэцийн тогтоол, 2024, №03). Сонгогдох эрх нь туйлын эрх биш тул сонгуульд нэр дэвшигчид буюу сонгогдох эрхээ хэрэгжүүлэгч иргэнд шалгуур, болзол, нөхцөл тогтоох нь сонгох эрхийг баталгаажулахад чиглэгддэг бөгөөд ийнхүү тогтоохдоо Үндсэн хуульт, ардчилсан ёсиг хамгаалах хууль ёсны зорилгод нийцсэн, үндсэн хуулийн эрх зүйн “хэмжээ хэтрэхгүй” байх зарчмын дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн хүрээнд хуулиар тодорхойлох боломжтой байна (Цэцийн дүгнэлт, 2020, №03). Иймээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгээр тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доoshгүй тооны сонгогчийн гарын үсгийг зуруулсан байхыг шаардаж байгаа нь бие даан нэр дэвшүүлэгчийн сонгогдох эрхийг зөрчсөн эсэхийг эрх зүйн тодорхой байдал, тохирсон байх зарчим, ялгаварлан гадуурхаагүй байх зарчмын дагуу шалгаж үзлээ.

### 1.1. Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хууль дээдлэх ёс нь териин үйл ажиллагааны үндсэн зарчим төдийгүй эрх зүйт терийг өргөн агуулгаар хамгаалдаг. Хууль дээдлэх ёс үндсэн эрхийг хуулиас гадуур хязгаарлахыг хориглох бөгөөд үндсэн эрхэд тавих хязгаарлалтыг хуульд хэлбэрийн хувьд тусгаснаар энэ зарчим хангагдахгүй, харин түүний үндэслэл, журмыг тодорхой хуульчлах буюу эрх зүйн тодорхой байдлыг хангах шаардлагатай (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Өөрөөр хэлбэл, үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах бөгөөд уг хязгаарлалт нь хоёрдмог утгагүй, тодорхой, үр дагаврыг урьдчилан таамаглаж, мэдсэнээр зан үйлээ нийцүүлэх боломжтой байдлаар хуульчилбал зохино (Цэцийн дүгнэлт, 2002, №02; 2020, №12; 2021, №02; Цэцийн тогтоол, 2002, №02).

Бие даан нэр дэвшүүлэгчийн цуглуулбал зохих гарын үсгийн доод хязгаарыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт тусгасан байх боловч эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэхийг холбогдох бусад заалттай хамт шалгах шаардлагатай байна.

#### 1.1.1. Сонгогчийн гарын үсэг зуруулах хугацаа

Нэр дэвшигчээр бүртгэхтэй холбоотой асуудлыг хуулиар тодорхой зохицуулах нь эрх зүйн тодорхой байдалд нийцнэ. Тухайлбал, бие даан нэр дэвшүүлэгч сонгогчийн гарын үсэг цуглуулахыг шаарддаг бол гарын үсэг зуруулахад боломжит хугацаа олгох бөгөөд зуруулж эхлэх, дуусах хугацааг тодорхой тусгах нь зүйтэй (ЕАБХАБ/АИХЭГ, 2013, х. 38).



Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт “Бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.”, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт “Аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтыг тэмдэг дарж баталгаажуулан бие даан нэр дэвшүүлэгчид энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагааг явагдаж эхэлсэн өдрөөс олгоно.” гэж заажээ. Үүнээс үзвэл 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг зуруулах нь бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааны нэг хэсэг мөн гэвэл гарын үсэг зуруулах ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгахаар байна. Нөгөө талаас тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсэгт “Бие даан нэрээ дэвшүүлэгч нь бие даан нэрээ дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дууссан өдрөөс хойш тав хоногт багтаан дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ;” гээд 32.3.2 дахь заалтад “сонгогчдын гарын үсэг зуруулсан маягт;” гэж заажээ. Баримт бичгийг ирүүлэх энэхүү тав хоногийн дотор нэр дэвшүүлэгч иргэн үргэлжлүүлэн гарын үсэг зуруулж болох эсэх нь хуулийн зохицуулалтаас ойлгомжгүй байна. Тодруулбал, бие даан нэр дэвшүүлэгч сонгогчийн гарын үсэг зуруулах ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгах, эсхүл уул хугацаан дээр нэмээд баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлэх хүртэлх тав хоногт (нийтдээ 12 хүртэл хоногт) үргэлжлүүлж болохоор хуульчилсан гэж үзэхээр байна.

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (цаашид “Сонгуулийн ерөнхий хороо” гэх)-ны 2024 оны 01 дүгээр тогтоолын Хавсралтаар баталсан “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах цаг хугацааны хуваарь”-ийн 23 дахь заалтад бие даан нэр дэвшүүлэх ажиллагааг 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс мөн оны 5 дугаар сарын 20-ны өдрийг дуустал явуулах, бие даан нэрээ дэвшүүлэгч мөн оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор баримт бичгийг тус хороонд ирүүлэхээр заажээ. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаан дээр өргөдөл гаргагч Д.Алтангэрэл Сонгуулийн ерөнхий хорооны баталсан хуваарь болон өгсөн зөвлөмжийн дагуу 12 хоногийн хугацаанд гарын үсэг цүглуулахаар байсан гэх тайлбарыг хийсэн. Үндсэн эрхийг хязгаарласан ердийн хуулийн зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлах боломжтой байвал үндсэн эрхэд илүү нийцсэнийг нь хэрэглэх шаардлагатай (Цэцийн дүгнэлт, 2024, №03).

#### 1.1.2. Сонгогчийн гарын үсгийг нягтлан шалгах, шийдвэрлэх журам

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.11 дэх хэсэгт “Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах хугацаа дууссанаас хойш долоо хоногийн дотор



бүртгэх эсэх асуудлыг шийдвэрлэж, тогтоол гаргана.” гэж зохицуулсан. Монгол Улсын Их Хурлын 2016 оны сонгуульд 69, 2020 оны сонгуульд 121, 2024 оны сонгуульд 42 бие даан нэр дэвшүүлэгч баримт бичгээ тус хороонд ирүүлжээ. Бие даан нэр дэвшүүлэгч бүр 801-ээс доошгүй сонгочийн гарын үсэг зуруулах шаардлагыг хангах зорилгоор дунджаар 1000 гарын үсэг цуглуулсан гэж үзвэл Сонгуулийн ерөнхий хороо нь нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авах хугацаа дууссанас хойш долоо хоногийн дотор 40.000-120.000 орчим сонгочийн гарын үсгийг нягтлан шалгах шаардлага үүснэ гэсэн үг. Сонгуулийн ерөнхий хороо аймаг, дүүргийн сонгуулийн хорооны дэмжлэг авсан ч долоо хоногийн дотор эдгээр гарын үсэг үнэн зөв эсэхийг нэг бүрчлэн нягтлан шалгах, бие даан нэр дэвшүүлэгч бүр 801-ээс доошгүй сонгочийн гарын үсэг зуруулсан эсэхийг тогтоох боломж хязгаарлагдмал. Ийм шалтгаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсэгт “Сонгуулийн ерөнхий хороо бие даан нэр дэвшигчийн цуглуулсан сонгогчдын гарын үсэг үнэн зөв эсэхийг түүвэрлэн тулгах, тухайн иргэнтэй уулзан нягтлан шалгаж болох бөгөөд шаардлагатай гэж үзвэл уг ажлыг аймаг, дүүргийн сонгуулийн хороогоор гүйцэтгүүлж болно.” гэж сонгочийн гарын үсгийг түүвэрлэн тулгахаар хуульчилсан гэж үзэхээр байна.

Сонгуулийн ерөнхий хороо Монгол Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулиар 3 бие даан нэр дэвшүүлэгчийг, 2020 оны ээлжит сонгуулиар 14 бие даан нэр дэвшүүлэгчийг, 2024 оны ээлжит сонгуулиар 4 бие даан нэр дэвшүүлэгчийг 801-ээс доошгүй сонгочийн гарын үсэг зуруулаагүй гэж нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан байна. Энэ тухай шийдвэрүүдэд цуглуулсан сонгочийн гарын үсгийн хэдэн хувийг хэрээн түүвэрлэн тулгасан, түүвэрлэн тулгахад ямар шалгур баримталсан, 801-ээс доошгүй сонгочийн гарын үсэг зуруулах шаардлагыг яагаад хангаагүй, ямар баримтад үндэслэсэн зэргийг заагаагүй байжээ.

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 221/ШШ2020/0009 дугаар шийдвэр, Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2020 оны 244 дугаар тогтоолоор бие даан нэр дэвшүүлэгч 1080 сонгочийн гарын үсэг цуглуулсанас 483 нь зөрчилтэй гэж үзэж нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан Сонгуулийн ерөнхий хорооны тогтоолыг; мөн Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 0010 дугаар шийдвэр, Монгол Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүх хуралдааны 2020 оны 245 дугаар тогтоолоор бие даан нэр дэвшүүлэгч 933 сонгочийн гарын үсэг цуглуулсанас 223 нь зөрчилтэй гэж үзэж нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан тус хорооны тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. Эдгээр шүүхийн шийдвэрээс үзэхэд эрх бүхий этгээд сонгочийн гарын үсгийг нягтлан шалгахдаа үзэмжээрээ буюу дур мэдэн хандах, холбогдох зөрчлийт баримтаар эргэлзээгүйгээр тогтоохгүй байх,

хэлбэрийн ялимгүй зөрчлийг үндэслэл болгох боломжийг дээрх хуулийн зохицуулалт олгож байна.

Бие даан нэр дэвшиүүлэгчийн цуглуулсан сонгогчийн гарын үсэг үнэн зөв эсэхийг түүвэрлэн тулгах, нягтлан шалгах үндэслэл, журмыг нарийвчлан хуульчлаагүй нь гарын үсгийг түүвэрлэн тулгахад эрх бүхий этгээдийн үзэмжээр тогтоох, цаг хугацаанд баригдан хайнга хандах, нягтлан шалгахгүй орхих, улмаар иргэн сонгогдох эрхээ эдлэх эсэхийг тодорхой, объектив шалгуураар бус, харин дур мэдэн шийдэх эрсдэл үүсгэж байх тул эрх зүйн тодорхой байдал алдагдсан байна. “Үндсэн эрхийн хэрэгжилтийг аль нэг албан тушаалтны үзэмж, дур мэдлээс хэт хамааралтай болгохоос татгалзах” шаардлагатай (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Гарын үсгийг нягтлан шалгах ажиллагаа нь тодорхой хэм хэмжээгээр зохицуулагдах ёстой (Венецийн комисс, CDL-AD (2002) 23). Үндсэн эрх үр дүнтэй хэрэгжих зарчмын дагуу сонгогдох эрхийг эдлүүлэх журам нь дур мэдэн шийдвэр гаргахаас сэргийлэх хангалттай баталгааг агуулсан байх хэрэгтэй (Хүний эрхийн Европын шүүх, 2015, №31953/11, догол 56).

Нягтлан шалгах ажиллагаа нь зарчмын хувьд бүх гарын үсгийг хамрах ёстой (Венецийн комисс, CDL (99) 66; CDL-AD (2002) 23). Иймээс бүх гарын үсгийг нягтлан шалгах зарчмыг хуульчлах, богино хугацааг хуулиар тогтоох тохиолдолд тухайн хугацаанд нягтлан шалгаж болохуйц тооны гарын үсгийг бие даан нэр дэвшиүүлэгчээс хуулиар шаардах нь зүйтэй. Хэрэв гарын үсгийг түүвэрлэн тулгах аргыг хэрэглэх тохиолдолд энэ талаар үндэслэл, журмыг тодорхой хуульчлах шаардлагатай байна. Тухайлбал, (а)нягтлан шалгах түүвэр (дээж)-ийн хэмжээ; (б)түүврийг авах арга (санамсаргүй тоонуудыг компьютероор үүсгэх зэрэг); (с)тодорхой гарын үсэг хүчинтэй эсэхийг тогтоох шалгур; (д)нэр дэвшигчээр бүртгэгдэхийн тулд хүчинтэй байх ёстой түүвэр дэх гарын үсгийн тоог тодорхойлох томъёо; (е)шаардлагатай бол нэмэлт түүвэр авах нөхцөл зэргийг тодорхой зохицуулах шаардлагатай (ЕАБХАБ/АИХЭГ, 2013, х. 38).

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэгт “Энэ хуульд заасан сонгогчдын гарын үсэг зуруулсан маягтыг нягтлан шалгахад бие даан нэрээ дэвшиүүлэгчээс үл хамаарах, сонгогчийн бичиг баримттай холбоотой зөрчил илэрсэн бөгөөд маягтын зөрчилгүй гарын үсгийн тоо нь энэ хуулийн 31.2-т заасан тооноос доошгүй бол дээрх зөрчил нь бие даан нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл болохгүй.” гэж заасан нь сонгогдох эрхийг эдлүүлэх, сонгуулийн төв байгууллагын ачааллыг бууруулах, үр нөлөөг дээшлүүлэх үүднээс зөвтгөх үндэслэлтэй байна. Шаардлагатай тооны гарын үсгийг цуглуулсан нь эргэлзээгүйгээр тогтоогдсон тохиолдолд үлдсэн гарын үсгийг нягтлан шалгах шаардлагагүй гэж үздэг (Венецийн комисс, CDL-AD (2002) 23).



Уг хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэгт “Сонгуулийн ерөнхий хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүлээн авахдаа бүрэн гүйцэд эсэхийг нягтлан шалгах ба хэрэв баримт бичгийн бүрдэл дутуу бол энэ хуульд заасан хугацаанд багтаан нөхөн ирүүлж болно.” гэж заасан. Сонгогчийн гарын үсэг зуруулах шаардлага нь баримт бичгийн бүрдэлд хамаарах эсэх, тус шаардлагыг хангагүй тохиолдолд бие даан нэр дэвшүүлэгчид нөхөж гарын үсэг цуглуулах боломж олгох эсэх, ийм боломж олговол ямар хугацаа өгөх зэрэг нь тус хуулийн зохицуулалтаас тодорхойгүй байна.

Бие даан нэр дэвшүүлэгч сонгогчийн гарын үсэг зуруулсан байхыг шаарддаг улсаас заримыг нь нарийвчлан судалбал нийтлэг байдлаар бүхэлд нь шалгах боломжтой тооны гарын үсгийг шаардах, сонгогчийн дэмжлэг авсан эсэхийг тогтооход зайлшгүй, гол мэдээллийг авах, зарчмын хувьд бүх гарын үсгийг нягтлан шалгах, нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэлийг хуульд тодорхой заах, шаардлагыг агуулгын хувьд хангасан бол хэлбэрийн ялимгүй зөрчлийг татгалзах үндэслэлд тооцохгүй байх, алдааг засах боломжийг хугацаа тогтоон олгох зэрэг зохицуулалтыг хуульдаа тусгасан байна. Тодруулбал, Австралийн Холбооны Улсад бие даан нэр дэвшүүлэгч 100-аас доошгүй сонгогчийн гарын үсэг цуглуулах бөгөөд уг босгын агуулгыг хангасан бол хэлбэрийн зөрчлөөс үүдэж нэр дэвшүүлэхээс татгалзахгүй хэмээн хуульчилжээ. Канад Улсад бие даан нэр дэвшүүлэгч нь 100-аас доошгүй сонгогчийн гарын үсэг цуглуулахдаа зөвхөн нэр, хаяг, гарын үсгийг гэрчийг байлцуулан зуруулахаар зааж, алдаатай тохиолдолд засварлах боломжит хугацааг олгохоор зохицуулсан. Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад бие даан нэр дэвшигч болон намаас нэр дэвшигч адил 200-аас доошгүй сонгогчийн гарын үсэг цуглуулахаар зааж алдаатай тохиолдолд засах боломжит хугацааг олгохоор хуульчилжээ. Бүгд Найрамдах Солонгос Улсад бие даан нэр дэвшүүлэгч 300-500 сонгогчийн гарын үсэг цуглуулах бөгөөд сонгогчийн нэр, гарын үсэг эсхүл тамга, төрсөн огноо, хаяг зэрэг мэдээллийг агуулсан байхаар заажээ. Эдгэрээрээс үзвэл сонгочоос шаардаж буй мэдээлэл нь гарын үсгийг үнэн зөв эсэхийг нягтлахад шаардлагатайгаас илүү биш байхаар зохицуулсан.

## 1.2. Тохирсон байх зарчмыг хангасан эсэх

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тусгасан хууль дээдлэх болон шударга ёсны зарчмын дагуу үндсэн эрхэд тавих хязгаарлалт тохирсон байна. Уг зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангах ёстой (Цэцийн дүгнэлт, 2024, №03; №04; Цэцийн тогтоол, 2024, №02; №03).

### 1.2.1.Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хууль ёсны зорилготой эсэх

Үндсэн эрхийн хязгаарлалт нь Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн хууль ёсны зорилготой байна (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар иргэний сонгох, сонгдох эрхийн хэрэгжилтийг хангахыг зорьжээ. Тус хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах, Монгол Улсын иргэний сонгох, сонгдох эрхийг хангахад оршино.” гэж заасан. Мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шутлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй.”, мөн зүйлийн 5.3 дахь хэсэгт “25 наасанд хүрсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр сонгогох эрхтэй.”, 5.6 дахь хэсэгт “Иргэний сонгох, сонгдох эрхийг хууль бусаар хязгаарлах, сонгогчоос саналаа чөлөөтэй өгөхөд нь хөндлөнгөөс нөлөөлөх, саад учруулахыг хориглоно.”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт “Сонгуулийн зарчим нь Монгол Улсын иргэний сонгох, сонгогох эрхийг хангахад үндэслэнэ.” гэж тус заасан байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар бие даан нэр дэвшиг боломжийг иргэнд олгосон нь сонгуулийн өрсөлдөөн, олон ургалч үзлийг дэмжих өрөнхий зорилготой байна. Тус хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт зааснаар бие даан нэр дэвшиүүлэгч тухайн сонгуулийн тойргийн сонгогчоос гарын үсэг зуруулсан байхыг шаардах нь иргэний сонгох эрхийг баталгаатай эдлүүлэх, улмаар ардчилсан сонгуулийг шударга, үр нөлөөтэй явуулах хууль ёсны зорилготой байна. Учир нь бие даан нэр дэвшиүүлэхэд тодорхой тооны гарын үсэг зуруулах эсхүл барьцаа төлүүлэх зэрэг бусад шаардлага хуулиар тогтоохгүй бол хэт олон тооны нэр дэвшигч сонгуульд өрсөлдөх буюу саналын хуудаст бичигдэж, сонгогчдод төөрөгдөл үүсгэж, нэр дэвшигч нараас үр нөлөөтэй сонголт хийх, саналаа өгөхөд бэрхшээл үүснэ (Хүний эрхийн Европын шүүх, 2015, №31953/11, догол 45, 58; Европын зөвлөл, 2022, х. 34). Нөгөө талаас бие даан нэр дэвшиүүлэгч сонгогчийн гарын үсэг цуглуулах нь сонгуулийн зардлыг бууруулах, сонгуулийг будилаантуулахгүй байх, түүнчлэн санал хураалт явуулах, санал тоолох, үр дүнг зарлах үйл явцыг удаашруулахаас сэргийлэх ач холбогдолтой байна (Өмнөд Африкийн Үндсэн хуулийн шүүх, 2023, CCT 158/23, х. 303).

Иргэний сонгох эрхийг баталгаатай эдлүүлэх, ардчилсан сонгуулийг явуулах хууль ёсны зорилгыг хангахын тулд бие даан нэр



дэвшүүлэгч (1) тухайн сонгуулийн тойрог дахь тодорхой тооны сонгогчийн гарын үсэг цуглуулах, (2) сонгуулийн дунд тодорхой босго санал авсан бол буцаан олгох нөхцөлтэйгээр барьцаа төлүүлэх, (3) өмнөх сонгуулийн дунд тодорхой тогтоосон босго давж санал авсан эсхүл ялалт байгуулсан байх зэрэг шаардлагын аль нэгийг хангах зохицуулалт нь арчилсан улсуудад түгээмэл байна. Гэхдээ бие даан нэр дэвшүүлэхэд эдгээр гурван шаардлагыг давхардуулан хэрэглэх нь улс төрийн олон ургалч үзлийг хязгаарлана гэж үздэг (ЕАБХАБ/АИХЭГ, 2013, х. 38). Тухайлбал, 1992 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын иргэн тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн дэмжлэг авсан нөхцөлд Улсын Их Хурлын гишүүнд нэрээ бие даан дэвшүүлэх эрхтэй.” гэж заахын зэрэгцээ мөн хуулийн 25 дугаар зүйлд намаас нэр дэвшигч эсхүл бие даан нэрээ дэвшүүлэгчээс үл хамааран “Улсын Их Хурлын гишүүнээр нэр дэвшигч бүр сонгуулийн тойргийн хороонд 10000 төгрөгийг барьцаа болгон өгнө. ...” гэж заан гарын үсэг болон барьцааны аргыг давхар хэрэглэж байжээ.

#### 1.2.2.Хууль ёсны зорилгод хүрэхэд уялдсан эсэх

Үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгыг хэрэгжүүлэхэд үйлчлэх буюу чиглэсэн байхыг уялдаатай байх шалгуур шаардана (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг нь иргэний сонгох эрхийг баталгаатай эдлүүлэх, улмаар арчилсан сонгуулийг шударга, үр нөлөөтэй явуулахад чиглэсэн байна. Өмнөх Улсын Их Хурлын сонгуульд хэт олон тооны бие даагч нэр дэвшээгүй нь энэ зохицуулалтын үйлчлэлийг харуулж байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар улсын хэмжээнд 2016 онд 69, 2020 онд 121, 2024 онд 42 бие даан нэр дэвшигч бүртгүүлсэн байна. Түүнчлэн 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг цуглуулах шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзаж ирсэн байна. Энэ талаар Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн тайлбар, лавлагаанд “... 1992 оноос хойш зохион байгуулагдсан Монгол Улсын Их Хурлын 9 удаагийн ээлжит сонгуулийн хугацаанд тухайн үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжийн дагуу бие даан нэрээ дэвшүүлэгчээс 801-ээс дээш тооны гарын үсэг зуруулсан байх шаардлага хангаагүй үндэслэлээр 2016 онд 3, 2020 онд 14, 2024 онд 4 бие даан нэрээ дэвшүүлэгчийг бүртгэхээс татгалзсан байна. ...” гэжээ. Үүнээс үзэхэд гарын үсэг зуруулах зохицуулалт нь дээр дурдсан хууль ёсны зорилготой уялдсан байна.

#### 1.2.3.Хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй эсэх

Үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй байна. Тус зорилгод хүрэхийн тулд авч боломжит, үр дүнтэй

арга хэмжээнүүдээс ижил үр дүнтэй боловч үндсэн эрхэд хамгийн бага халдсан арга хэмжээг нь сонгохыг энэ зарчим шаардана (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Бие даан нэр дэвшигүүлэхэд тодорхой тооны сонгогчийн гарын үсэг зуруулсан байхаар хуульчлах боломжтой ч энэ тохиолдолд гарын үсгийн тоо нь хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүйгээс хэтэрч болохгүй. Бие даан нэр дэвшихийн тулд цуглуулах сонгогчийн гарын үсгийн тоог хэт өндөр тогтоовол сонгогдох эрхийг хэрэгжүүлэхэд саад учруулж болзошгүй. Иймээс цуглуулах гарын үсгийн тоо нь хууль ёсны зорилгыг хангах хэмжээнд хамгийн бага түвшинд байвал зохино. Тодруулбал, парламентын сонгуульд нэр дэвшихэд цуглуулах гарын үсгийн тоо нь тухайн тойротг бүртгэгдсэн сонгогчийн нэг хувиас илүүгүй байх бөгөөд олон мандаттай тойротг тухайн тойргийн сонгогчийг суддлын тоонд хуваасны нэг хувиас илүүгүй байхыг зохистойд тооцдог байна (Венецийн комисс, CDL (99) 66; CDL-AD (2002) 23; CDL-AD (2010) 007).

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцоонд олныг төлөөлөх арга (нэг мандаттай, олон мандаттай томсгосон эсхүл бүсчилсэн)-ын алийг хэрэглэж байгаагаас хамааран бие даан нэр дэвшигүүлэгчийн зуруулах 801-ээс доошгүй тооны гарын үсэг тухайн тойргийн сонгогчийн хэдэн хувь байх нь тодорхойлогдож иржээ. Монгол Улсын Их Хурлын нийт 9 удаагийн сонгуулийн 7 нь олныг төлөөлөх тогтолцоогоор, 2 нь холимог тогтолцоогоор явагдсан. Тодруулбал, Улсын Их Хурлын 76 гишүүнийг 1996, 2000, 2004, 2016 онд 1 мандаттай 76 тойроос, 1992, 2008, 2020 онд олон мандаттай, томсгосон тойроос олныг төлөөлөх (мажоритар) аргаар сонгосон бол 2012 онд 48 гишүүнийг олон мандаттай, томсгосон 28 тойроос олныг төлөөлөх аргаар, 28 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх (пропорциональ) аргаар, харин 2024 онд Улсын Их Хурлын 126 гишүүний 78-ыг нь олон мандаттай, бүсчилсэн 13 тойроос олныг төлөөлөх аргаар, 48-ыг нь хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгосон байна.

Бие даан нэр дэвшигүүлэгчээс 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг цуглуулахыг шаардаж байгаа нь Монгол Улсын хүн ам (3.5 сая орчим), нийт сонгогч (2.1 сая орчим)-ийн болон тухайн тойргийн сонгогчийн тоотой харьцуулахад хэт өндөр босго гэж үзэхээр байна. Сүүлийн гурван удаагийн Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар бие даан нэр дэвшигүүлэгчийн зуруулах 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг нь тухайн тойргийн сонгогчийн 1 хувиас доош байсан тохиолдол байхгүй, харин 1-5 хувь эзэлж байсан нь зайлшгүй бус дарамт, ачааллыг бие даан нэр дэвшигүүлэгчид үүсгэсэн байна. Тодруулбал, 2016 оны Улсын Их Хурлын сонгууль нь 1 мандаттай 76 тойрог бүхий олныг төлөөлөх тогтолцоогоор явагдсан бөгөөд тойрог бурийн нийт сонгогчийн тоог 801 тоотой харьцуулахад 1 тойротг 1-2, 24 тойротг 2-3, 34 тойротг 3-4, 14 тойротг 4-5, 3 тойротг 5-аас дээш хувийг эзэлж байжээ. 2020 оны Улсын Их Хурлын сонгууль нь олон мандаттай, томсгосон 29 тойрог бүхий олныг төлөөлөх тогтолцоогоор явагдсан. Иймээс



тухайн тойргийн нийт сонгогчийг суудлын тоонд хувааж харьцуулбал 801 гарын үсэг нь 2020 онд 3 тойротг 1-2, 6 тойротг 2-3, 14 тойротг 3-4, 6 тойротг 4-5 хувийг ээлсэн байна. 2024 оны Улсын Их Хурлын сонгууль нь холимог тогтолцоогоор явагдсан бөгөөд 126 гишүүний 78-ыг нь олон мандаттай, бүсчилсэн 13 тойргоос олныг төлөөлөх аргаар сонгосон. 801 гарын үсэг нь эдгэр 13 тойрог бүрийн нийт сонгогчийг харгалзах суудлын тоонд хуваавал 4 тойротг 1-2, 1 тойротг 2-3, 5 тойротг 3-4, 3 тойротг 4-5 хувь байжээ.

Бие даан нэр дэвшүүлэгч сонгогчийн гарын үсэг цуглуулахыг шаарддаг улс цөөнгүй байх ч Монгол Улстай адил хэт өндөр тоо тавихаас татгалзах нийтлэг чиг хандлагатай байна. Тухайлбал, олныг төлөөлөх тогтолцоо бүхий Австралийн Холбооны Улс (хүн амын тоо: 26 сая орчим)-д 100, Бүгд Найрамдах Ботswana Улс (хүн амын тоо: 2.5 сая орчим)-д 7, Канад Улс (хүн амын тоо: 39 сая орчим)-д 100, Бүгд Найрамдах Энэтхэг Улс (хүн амын тоо: 1.4 тэрбум орчим)-д 10, Бүгд Найрамдах Маврики Улс (хүн амын тоо: 1.2 сая орчим)-д 4, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс (хүн амын тоо: 69 сая орчим)-д 10 тооны сонгогчийн гарын үсгийг; сонгуулийн холимог тогтолцоо бүхий Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (хүн амын тоо: 84 сая орчим)-д 200, Бүгд Найрамдах Грек Улс (хүн амын тоо: 10 сая орчим)-д 12, Бүгд Найрамдах Солонгос Улс (хүн амын тоо: 51.7 сая орчим)-д 300-500 тооны сонгогчийн гарын үсгийг; хувь тэнцүүлэн төлөөлөх тогтолцоо бүхий Бүгд Найрамдах Албани Улс (хүн амын тоо: 2.7 сая орчим)-д 1 хувиас доошгүй, Данийн Хаант Улс (хүн амын тоо: 5.9 сая орчим)-д 150-200, Бүгд Найрамдах Финланд Улс (хүн амын тоо: 5.6 сая орчим)-д 100, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (хүн амын тоо: 64 сая орчим)-д 1000 сонгогчийн гарын үсгийг цуглуулахаар хуульчилсан байна.

Олон улсын сонгуулийг ажиглах хорооноос Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг ажиглаад гаргасан мэдэгдэл “СЕХ нэр дэвшигчдийг бүртгэхдээ хуулийг баримталж, шаардлагатай материалыа засах хугацааг олгож байсан хэдий ч нэр дэвшигчдэд тавигдах хэт их шаардлага нь сонгдох эрхийг бүх нийтэд эдлүүлэхэд эргэлзээ төрүүлж байна.” гэжээ. Ийм хэт их шаардлагын нэг нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийн зохицуулалт байна. Учир нь сонгогчийн гарын үсгийн босгыг тогтооходоо тухайн тойргийн нийт сонгогчийн тоо болон гарын үсэг зурах сонгогчийн тооны зохист харьцааг харгалзаагүй, 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг зуруулахаар хатуу хуульчилсан нь бие даан нэр дэвшүүлэгчээс зайлшгүйгээс илүү тооны гарын үсэг цуглуулахад хүргэж байна. Энэ нь Монгол Улсын хүн ам, нийт сонгогчийн тоотой харьцуулахад хэт өндөр босго байх тул сонгodoх эрхийг хамгийн багаар хязгаарласан арга зам гэж үзэхгүй. Хууль тогтоогч Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн

1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх аргаар сонгохдоо түүний аль хувилбар (нэг мандаттай, олон мандаттай томсогсон эсхүл бүсчилсэн)-ыг хэрэглэж байгаагаас үл хамааран гарын үсэг цуглуулахад хэрэглэх тогтвортой тоог хуульчилж болох ч тэр тоо нь тухайн тойргийн сонгогчийн тоонд нийцсэн, хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй, үндэслэл бүхий байх нь зүйтэй байгааг тэмдэглэж байна.

#### 1.2.4. Тэнцвэртэй эсэх

Хууль ёсны зорилгыг хангаснаар хүрэх үр дүн болон хөндөгдөж буй эрхийг хэрэгжүүлэх шаардлага хоорондын тэнцвэрийг хангана. Тодруулбал, үндсэн эрхийг хязгаарласнаар хангагдах ашиг сонирхол нь халдаж буй эрхийг хамгаалах ашиг сонирхлоос дээгүүр байвал тухайн хязгаарлалт нь хууль дээдлэх болон шударга ёсны үүднээс зөвтгөгдхө боловжтой. Харин зорилгод хүрэх цорын ганц арга нь хэт өндөр үнээр хэрэгжих тохиолдолд тухайн аргыг хууль ёсны байсан ч ашиглаж болохгүй (Цэцийн дүгнэлт, 2024, №03).

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг нь тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг зуруулахыг бие даан нэр дэвшигчээд үүрэгжүүлэх замаар сонгдох эрхийг хязгаарлаж байгаа боловч энэ нь иргэний сонгох эрхийн хэрэгжилтийг хангаж, ардчилсан сонгуулийн ашиг сонирхлыг хамгаалж байна. Гэвч 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг цуглуулахыг шаардаж, энэ хэт өндөр босгыг эсхүл түүнд холбогдох зохицуулалтыг хэлбэрийн хувьд ялимгүй хэмжээнд зөрчсөн тохиолдолд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл болохоор хуульчилсан нь тэнцвэртэй байх шалгурт нийцэхгүй байна.

Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл нь хуулийн хүрээнд тодорхой заасан, объектив шалгуурт тулгуурласан байвал зохино (ЕАБХАБ/АИХЭГ, 2013, х. 38). Гэвч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт нэр дэвшигчээр дараах тохиолдолд бүртгэхээс татгалзана гээд 33.1.2 дахь заалтад “энэ хуульд заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй;”, 33.1.4 дэх заалтад “нэр дэвшигчээр бүртгүүлэхэд шаардагдах энэ хуульд заасан баримт бичиг дутуу;” гэж заажээ. Бие даан нэрээ дэвшигчээр 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг зуруулаагүй нь нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах эдгээр үндэслэлийн алинд хамаарахыг тодорхой хуульчлаагүй байна. Сонгуулийн ерөнхий хорооноос Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай тогтоолуудад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасан тус шаардлагыг хангаагүй тохиолдлыг тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтыг үндэслэл болгосон байгааг дурдах нь зүйтэй.



Учир нь нэр дэвшигчид тавигдах шаардлагыг агуулгын хувьд хангасан ч хэлбэрийн төдий ялимгүй зөрчсөн байх нь “хуульд заасан нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангагүй”-д тооцогдож нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах үндэслэл болохоор байна.

Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсанаар холбогдох иргэний сонгогдох эрхийг тухайн сонгуульд эдлүүлэхгүй байх үр дагавартай тул энэ арга хэмжээг гагчхүү адил түвшний ноцтой зөрчилд хэрэглэвэл зохино. Иймд бие даан нэр дэвшүүлэгч нь тухайн тойргийн сонгогчийн гарын үсэг зуруулах босгыг агуулгын хувьд хангасан ч хэлбэрийн төдий ялимгүй зөрчил (зарим нарийвчилсан мэдээлэл дутуу эсхүл техникийн алдаатай зэрэг) гаргасан үндэслэлээр нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах нь шударга ёс болон ардчилсан ёсны үүднээс зөвтгөх үндэслэлгүй болно. Дэмжиж байгаа сонгогчийн гарын үсгийн тоо дутуу байгааг хангалттай баримтаар тогтоох, ялимгүй зөрчлийг үндэслэл болгож нэр дэвшигчээр бүртгэхээс шууд татгалзахгүй байх, мэдээллийн алдааг засах боломжит хугацаат бие даан нэр дэвшүүлэгчид олгох зэргээр зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон зохицуулалтыг хийх учиртай (Венецийн комисс, CDL-INF (2000) 17).

### 1.3. Ялгаварлан гадуурхсан эсэх

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэгш байдлын зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь ялгаварлан гадуурхсан шинжтэй байж болохгүй. Түүнчлэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасан. Энэ заалт нь хүн бүр хууль болох хувьдаа угаас тэгш гэсэн нийтлэг итгэл үнэмшилд тулгуурлаж, хүн бүрийг адилхан хүн гэж хүлээн зөвшөөрч хүний ёсоор хүндлэх үргийг тэр хүлээнэ. Тэгш байх эрхийн ноцтой зөрчлийн нэг бол ялгаварлан гадуурхал юм. Иймээс Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэж тусгайлан заасан бөгөөд энд дурдсан эсхүл дурдагдаагүй шинж (хөгжлийн бэрхшээл зэрэг)-ээр нь ялгаварлан гадуурхсан хязгаарлалтыг үндсэн эрхэд тавьж болохгүй (Цэцийн дүгнэлт, 2017, №07).

Тэгш байх эрх нь үндсэн эрхүүдийн дотроос хамгийн өргөн хүрээг хамардаг эрхийн нэг бөгөөд ялгаварлан гадуурхаагүй байх зарчмын хамтаар бусад үндсэн эрхийг хамгаалах суурь болдог. Тэгш байх эрх, ялгаварлан гадуурхаагүй байх зарчим нь хүн бүрд бүх талаар тэгш хандах утгыг илэрхийлэхгүй бөгөөд адил төсөөтэй нөхцөлд байгаа хүмүүст тэгш хандах, харин ялгаатай нөхцөлд байгаа хүмүүст тэгш бус хандах агуулгатай.

Иймээс үндсэн эрхэд тавих хязгаарлалт нь зохих үндэслэлтэйгээр хүнд ялгаатай хандсан бол ялгаварлан гадуурхал болохгүй. Энэ үзэл баримтлалын дагуу Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсгийг шалгалаа.

1.3.1. Тэгш байх эрхийн дагуу хуулиар болон хуулийг хэрэгжүүлэхдээ хүнд дур мэдэн ялгаатай хандахыг хориглоно. Иймээс үндсэн эрхийг эдлүүлэх хүрээнд зохих үндэслэлгүйгээр ялгаатай хэрэгжүүлэхүйц зохицуулалтыг хуульчилж болохгүй. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8 дахь хэсэгт Сонгуулийн ерөнхий хороо бие даан нэр дэвшигчийн цуглувулсан сонгогчдын гарын үсэг үнэн зөв эсэхийг түүвэрлэн тулгах, тухайн иргэнтэй уулзан нягтлан шалгаж болохоор заасан. Бие даан нэр дэвшиүүлэгчийн цуглувулсан гарын үсгийг бүгдийг нь нягтлан шалгах бус, харин түүвэрлэн тулгахаар хуульчилсан байх бөгөөд түүвэрлэн тулгах үндэслэл, журмыг тодорхой хуульчлаагүйгээс эрх бүхий этгээд үзэмжээрээ буюу дур мэдэн шийдвэрлэх, улмаар адил эрх зүйн субъектэд буюу бие даан нэр дэвшиүүлэгч нарт зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандах нөхцөлийг бий болгож, тэгш байх эрхийг нь зөрчихд хүргэж байна.

Тодорхой нам, нэр дэвшигчийн төлөө эсхүл эсрэг урвуулан ашиглах, ялгаварлан гадуурхахаас сэргийлэхийн тулд гарын үсгийг нягтлан шалгах журмыг нарийвчлан зохицуулж, ялгаварлан гадуурхахааргүй байх объектив хэм хэмжээг тогтоож хэрэгжүүлэх шаардлагатай (ЕАБХАБ/АИХЭГ, 2013, х. 39). Эс бөгөөс аль нэг нэр дэвшигчийн ирүүлсэн гарын үсгийн жагсаалтыг маш нарийн нягталж, негөө нэр дэвшигчээс ирүүлсэн жагсаалтыг огт нягтлан шалгахгүйгээр баталж, нэр дэвшигчээр бүртгэх эрсдэл үүснэ. Иймээс гарын үсгийг хэрхэн нягтлан шалгах талаар тодорхой хуульчилж, энэ журам нь бүх бие даан нэр дэвшиүүлэгчид адилхан үйлчлэх баталгааг бүрдүүлбэл зохино.

1.3.2. Тэгш байх зарчмын дагуу ялгаа бүхий эрх зүйн байдалтай субъектэд ялгаатай хандахыг зөвшөөрөх бөгөөд гагцхүү энэ ялгаа нь үндэслэлтэй байхыг шаардана. Үүнээс үзвэл нам, эвслээс нэр дэвшигч болон бие даан нэр дэвшиүүлэгч нь эрх зүйн байдлын хувьд ялгаатай учир өөр өөр шаардлагыг тухайлан хуульчлахыг Үндсэн хуулиар хориглоогүй. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлагыг, тус хуулийн 30 дугаар зүйлд нам, эвслээс, 31 дүгээр зүйлд бие даан нэр дэвшиүүлэх ажиллагааг ялгаж зохицуулжээ.

Улсын Их Хурлаас 2023 онд баталсан Улс төрийн намын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого



дэвшиүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн.” гэж заасан бөгөөд тус хуульд заасан журмаар намыг үсгэн байгуулж, бүртгүүлснээр үйл ажиллагаа явуулах эрхтэй болдог. Энэ онцлогтой нь уялдуулан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэгт “Намаас нэр дэвшиүүлэх асуудлыг тухайн намын Их хурал, эсхүл төлөөллийн төв байгууллага хуралдаанаараа хэлэлцэж, нууцаар санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ.” гэж тусгасан байна. Түүнчлэн Улс төрийн намын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.6 дахь заалтын дагуу намыг бүртгүүлэх өргөдөл “намын 801-ээс доошгүй гишүүний бүртгэл /ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, утасны дугаар, цахим шуудангийн хаяг, гарын үсэг;/”-ийг хавсаргахаар заасан байна. Нам байгуулахад 801-ээс доошгүй гишүүний бүртгэлтэй байхыг 1990 оны Улс төрийн намуудын тухай хуулийн 5 дугаар зүйлийн /в/ заалт болон 2005 оны Улс төрийн намын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.7 дахь заалтаар адилхан шаардаж, гишүүдийн тоо нь 801-д хүрээгүй бол Улсын дээд шүүх тухайн намыг бүртгэхээс татгалзах үндэслэл болохоор хуульчилж иржээ.

Улс төрийн нам, эвслээс нэр дэвшигчээс ялгаатай нь бие даан нэр дэвшиүүлэгч иргэн өөрөө сайн дурын үндсэн дээр сонгогдох эрхээ здэлж дангаараа сонгуульд оролцдог. Иймээс энэхүү онцлогийн дагуу “... нэр дэвшигчид тавигдах нийтлэг шаардлагыг хангаж буй иргэн тухайн нэр дэвших гэж буй тойргийн сонгогчдоос дэмжлэг авснаар бие даан нэрээ дэвшиүүлэх эрх нь үүсдэг” (Сонгуулийн ерөнхий хорооноос ируулсэн тайлбар, лавлагaa). Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшиүүлэгч нь тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсгийг зуруулахаар тусгажээ.

Бие даан нэр дэвшиүүлэгч сонгогчийн гарын үсэг зуруулахаар хуульчилж болох ч намыг бүртгүүлэхэд тавигддагтай адил тооны сонгогчийн гарын үсгийг цуглуулах босгыг зөвхөн нэг иргэнээс шаардах нь илүү дарамт, ачааллыг зохих үндэслэлгүйгээр үүсгэхээр байна. Намыг бүртгүүлэхэд шаардлагатай гишүүний гарын үсэг зуруулах нь бие даан нэр дэвшиүүлэгч сонгогчийн гарын үсэг зуруулаас харьцангуй хялбар байна. Тодруулбал, бие даан нэр дэвшиүүлэгч нь дангаараа богино хугацаа (долоо эсхүл 12 хүртэл хоног)-ны дотор зөвхөн тухайн тойргийн сонгогчоос 801-ээс доошгүй гарын үсэг зуруулах бөгөөд энэхүү жагсаалтыг нэг удаа буюу тухайн сонгуульд ашиглана. Нам байгуулах зорилгоор иргэд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, хамтаараа харьцангуй урт хугацаанд тодорхой тойргийн хязгаарлалтгүйгээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хаана ч оршин суудаг иргэдээс 801-ээс доошгүй гарын үсэг зуруулах боломжтой байна. Энэ шаардлагыг хангаж

байгуулагдсан нам холбогдох сонгуульд хуульд заасны дагуу оролцох эрхтэй бөгөөд сонгуульд оролцох бүрд 801-ээс доошгүй сонгочийн гарын үсэг зуруулах үүрэггүй. Мөн намыг бүртгүүлэх өргөдөл түүний гишүүний регистрийн дугаарыг, харин бие даан нэр дэвшиүүлэгчийн сонгочийн гарын үсэг цуглуулах маягтад иргэний бүртгэлийн дугаарыг бичсэн байхаар ялгаатай хуульчилжээ. Иргэн регистрийн дугаарыг тогтмол хэрэглэдэг тул бүртгүүлэхэд хялбар бол, иргэний бүртгэлийн дугаарыг тогтмол ашигладаггүйгээс тэр бүр мэддэггүй тул дэмжиж гарын үсэг зурахгүй байх нөхцөл үүсэхээр байна.

Хувь хүний үндсэн эрх, эрх чөлөөний хамгаалагдсан хүрээ рүү халдах нь их тусам ялгаатай хандлагыг зөвтгөх үндэслэл төдий чинээ хүчтэй байна. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар нэр дэвшигч нарын шаардлагыг тогтоохдоо бие даан нэр дэвшиүүлэгчид нам, эвслээс нэр дэвшигчид тавьж буйгаас хэт өндөр босгыг тогтоосон байх тул энэхүү ялгааг төдий чинээ зөвтгөх үндэслэлтэй байх шаардлагатай. Бие даан нэр дэвшиүүлэгч нь намаас санал болгосон нэр дэвшигчтэй адил боломжтой байх бөгөөд тавих шаардлага нь нам, эвслээс нэр дэвшигчид тавих шаардлагаас хэтрүүлэн хязгаарласан шинжтэй байж болохгүй (Венецийн комисс болон ЕАБХАБ/АИХЭГ, CDL-AD (2010) 024, догол 146). Дээр дурдсанчлан бие даан нэр дэвшиүүлэгч тухайн тойргийн 801-ээс доошгүй сонгочийн гарын үсэг зуруулахаар заасан нь сонгогдох эрхээ өдлэхэд саад болохуйц хэт өндөр байх бөгөөд нам, эвслээс нэр дэвшигч болон бие даан нэр дэвшиүүлэгчийн хооронд үүсэх хэт ялгаатай байдлыг зөвтгөх үндэслэл тогтоогдохгүй байна.

Үндсэн хуулийн Арван дерөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “үзэл бодол”-оор нь ялгаварлан гадуурхаж болохгүй бөгөөд үзэл бодол гэдэг нь энэ маргааны хувьд намд элсэх, намаас гарах, намд элсэхгүй байх, нам, эвслээс эсхүл бие даан сонгуульд нэр дэвших зэргээ өөрөө шийдвэрлэх агуулгаар хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, бие даан нэр дэвших нь үзэл бодлын илэрхийлэл бөгөөд эвлэлдэн нэгдэх эрх нь эвлэлдэн нэгдэх эсхүл нэгдэхгүй байх эрхийг багтаана. Үндсэн хуулийн цэцийн 2024 оны 03 дугаар тогтоолын агуулгаас харвал иргэн нам байгуулах эсхүл түүнд гишүүнээр элсэх позитив эрхтэй төдийгүй түүнд элсэхгүй байх, тус намаас гарах негатив эрхтэй. Иймээс бие даан нэр дэвшиүүлэгчид сонгуульд нэр дэвшихэд нам, эвслээс нэр дэвшихээс ялгаатай шаардлага тогтоож болох ч маргаан бүхий зохицуулалт нь бие даан нэр дэвшиүүлэх боломжийг хэт хязгаарлаж, улмаар зохих үндэслэлгүйгээр намын гишүүнд давуу боломжийг бий болгосон нь тэгш байх эрхийн зарчмыг зөрчиж, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхсан гэж үзэхээр байна.

#### 1.4. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг



1.4.1. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд заасны дагуу Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үргээ биелүүлж, дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрдөнө. Иймээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт (цаашид “Пакт” гэх)-аар хүлээсэн үргээ шударгаар сахин биелүүлж, түүний ерөнхий тайлбарыг нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчим гэж үзэж баримтална.

Төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох төдийгүй төрийн алба хаших эрх нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ бөгөөд уг эрхийг баталгаатай эдлүүлэх нь олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг мөн. Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 21 дүгээр зүйлийн 1 дахь хэсэгт “Хүн бүр улсаа удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.”, 2 дахь хэсэгт “Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй.”, 3 дахь хэсэгт “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.” гэж тус тус заажээ. Түүнчлэн Пактын 25 дугаар зүйлд зааснаар иргэн бүр (а) “төрийн хэргийг явуулахад шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох;” (б) “сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох;” (с) “тэгш эрхийн ерөнхий нөхцөлтэйгээр улсдаа төрийн алба хаших.” эрх, боломжийг аливаа ялгаварлан гадуурхалгүйгээр болон үндэслэлгүй хязгаарпалтгүйгээр эдэлнэ.

1.4.2. 1996 онд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос Пактын 25 дугаар зүйлээр хамгаалсан эрхийн тухай 25 дугаар ерөнхий тайлбарыг гаргасан. Тус тайлбарын 15 дахь доголд “Сонгогдох эрхийг үр дүнтэй хэрэгжүүлж, эдлэх боломжоор хангах нь сонгогч нэр дэвшигчдээс чөлөөтэй сонгох нөхцөлийг бүрдүүлнэ.” гэж тус эрхийн ач холбогдлыг тодотгоод “... сонгогдох эрхэд тавих аливаа хязгаарлалт нь бодитой (объектив), үндэслэлтэй шалгуураар зөвтгөдөхүйц байх ёстой.” гэжээ. Түүнчлэн Ерөнхий тайлбар (1996, №25)-ийн 17 дахь доголд “Улс төрийн намын гишүүн байх, эсхүл аль нэг тодорхой намын гишүүн байх үндэслэлгүй шалгуураар нэр дэвших, сонгогдох эрхийг хязгаарлахыг хориглоно. Нэр дэвшихийн тулд тодорхой тооны сонгогч, дэмжигчдийн гарын үсгийг цуглуулах шаардлага тавьдаг бол уг шаардлага нь үндэслэл бүхий байх бөгөөд нэр дэвшихэд саад болох ёсгүй. Энэхүү Пактын 5 дугаар зүйлийн

(1) дэх хэсэгт заасанчлан аливаа иргэний улс төрийн үзэл баримтлал, байр суурийг сонгогдох эрхийг нь хязгаарлах үндэслэл болгож болохгүй.” гэжээ.

Улсын Их Хурлын сонгуульд бие даан нэр дэвшүүлэгч 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсгийг зуруулахаар хуульчилсан нь Монгол Улсын хүн ам, нийт сонгогчийн болон тухайн тойргийн сонгогчийн тоотой харьцуулахад хэт өндөр босго байхын зэрэгцээ ийнхүү гарын үсэг зуруулах хугацаа богино, маягтад нарийн мэдээллийг тодорхой бичихийг шаардсан, гарын үсгийг долоо хоногийн хугацаанд түүвэрлэн шалгахаар заасан, гарын үсгийн босгыг агуулгын хувьд хангасан ч холбогдох зохицуулалтыг ялимгүй зөрчсөн гэж нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах боломжтой, алдаа засах боломжит хугацааг хуулиар олгодог эсэх нь эргэлзээтэй, холбогдох үндэслэл, журам нь тодорхойгүй байх тул Ерөнхий тайлбар (1996, №25, догол 17)-т заасан “үндэслэл бүхий байх бөгөөд нэр дэвшихэд саад болохгүй байх” зарчимд нийцээгүй байна. Иймд маргаан бүхий зохицуулалт нь Пактын 25 дугаар зүйлийн (b) хэсэгт заасан сонгогдох эрхийг зерчиж, улмаар Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасанд нийцэхгүй байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх

2.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт заасан “Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягт”-ын агуулгыг мөн зүйлийн 31.4 дэх хэсэгт “Сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна.” гэж 2019 онд хуульчилсан байсан бөгөөд энэ хэсгийн “регистрийн” гэснийг “иргэний бүртгэлийн” гэж 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар өөрчилжээ. Энэ өөрчлөлттэй холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2020 оны “Маягт батлах тухай” 19 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан Бие даан нэрээ дэвшүүлэгчийн сонгогчийн гарын үсэг зуруулах маягтын В баганын “Регистрийн дугаар” гэснийг “Бүртгэлийн дугаар” болгосон байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн албан бичигт “… иргэний регистрийн дугаарыг Монгол Улсын иргэн төрсний бүртгэлд анх удаа бүртгүүлэх, Монгол Улсын харьяат болоход олгож байгаа бөгөөд тухайн иргэнд олгосон регистрийн дугаар нь аймаг, нийслэл, сум, дүүргийг илэрхийлсэн үсгэн утга, төрсөн он, сар,



өдөр, хүйсийг илэрхийлсэн тоон утгыг агуулж байдаг тул регистрийн дугаараар тухайн иргэний төрсөн он, сар, өдөр, хүйсийн мэдээлэл, оршин сууж байсан аймаг, нийслэл, сум, дүүргийн мэдээллийг мэдэх боломжтой байдаг. Иргэний регистрийн дугаарыг эрх бүхий этгээдийн шийдвэрээр өөрчилж хүчингүй болгох эрх зүйн зохицуулалт байдаг бол иргэний бүртгэлийн дугаарыг өөрчлөх боломжгүй юм. Иргэний бүртгэлийн дугаарыг хэрэглээнд нэвтрүүлснээр төрөөс үзүүлж буй үйлчилгээ болон төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцоход өөрчлөгддөггүй, дахин олгогддоггүй, давхарддаггүй, сольдоггүй, нэгдсэн нэг дугаар ашиглах боломжтой болж, үнэн зөв нэг эх сурвалжийн мэдээлэлд үндэслэн иргэний үнэмлэхийн хэрэглээг нэмэгдүүлэх замаар төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр түргэн шуурхай, хүртээмжтэй үзүүлэх улмаар хүний хувийн мэдээллийг хамгаалах нөхцөлийг бүрдүүлсэн.” гэсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооноос Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар, лавлагаанд “... Тус Хорооны хувьд бие даан нэрээ дэвшүүлэгч нь гарын үсэг зуруулах маягтад регистрийн дугаар, эсхүл иргэний бүртгэлийн дугаар алийг нь ч бичсан тооцно. Учир нь регистрийн дугаар, эсхүл иргэний бүртгэлийн дугаар нь гагцхуу тухайн гарын үсэг зуруулсан дэмжигч сонгогч нь бие даан нэрээ дэвшүүлэгчийн тойргийн нутаг дэвсгэрт буюу тухайн тойргийн сонгогч мөн эсэх мэдээллийг нягтлан шалгахад шаардлагатай мэдээлэл юм. ...” гэжээ. Иргэний бүртгэлийн дугаар төдийгүй регистрийн дугаарыг маягтад бөглөсөн тохиолдолд Сонгуулийн ерөнхий хороо аль алийг нь тооцсон нь хуулийн талаарх өөр өөр тайлбаруудаас сонгогдох эрхийг хангахад илүү нийцсэнийг нь хэрэглэсэн гэж үзэхээр байна. Гэвч иргэний бүртгэлийн болон регистрийн дугаарыг багтаасан ийм өргөн агуулгаар хуулийг хэрэглэх тухай бие даан нэр дэвшүүлэгч наарт урьдчилан мэдэгдсэн эсэх талаарх мэдээлэл ирүүлээгүй болно. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх хэсэгт “иргэний бүртгэлийн дугаар”-ыг тодорхой бичихийг шаардаж, Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад “Бүртгэлийн дугаар” гэж бичсэн байгаа учраас регистрийн дугаарыг иргэний бүртгэлийн дугаарт оруулан тооцох эсэх нь тус хорооны холбогдох албан хаагчийн үзэмж, дур мэдлээс хамаарах эрсдэлтэй байна. Түүнчлэн маягтад “Бүртгэлийн дугаар” гэж бичигдэн тараагдсан учраас бие даан нэр дэвшүүлэгчийг дэмжиж байгаа ч сонгогч нь иргэний бүртгэлийн дугаараа мэдэхгүйгээс маягтад гарын үсэг зурахгүй байх, эсхүл маягтын дагуу мэдээлэл цуглуулахад ойлгомжгүй, төвөгтэй байдал бий болгохоор байгааг дурдах нь зүйтэй.

Иймд тухайн тойргийн сонгогч мөн эсэхийг тогтооход зайлшгүй, гол мэдээллийг шаардах (тухайлбал иргэний бүртгэлийн дугаар, регистрийн дугаар, эсхүл оршин суугаа газрын хаягийн аль нэгийг бичих), мөн сонгочийн гарын үсгийг цахимаар цуглуулахыг зөвшөөрөх зэрэг асуудлыг хуулийг боловсронгуй болгох хүрээнд шийдвэрлэх боломжтой.



2.2. Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маят нь зөвхөн “бие даан нэрээ дэвшигүүлэгчийн тойргийн нутаг дэвсгэрт буюу тухайн тойргийн сонгогч мөн эсэх мэдээллийг нягтлан шалгах” хууль ёсны зорилгыг хангахад зайлшгүй хэмжээний мэдээллийг авах, аль болох энгийн, ойлгомжтой хэлбэртэй байвал зохино. Гэвч 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд хэрэглэсэн маягтын “оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаар” бичих талбар нь хэт жижиг, мөр хоорондын зайд хэт ойр байсан нь сонгогчоос эдгээр мэдээллийг бүрэн гүйцэд бичихэд хүндэрэл үүсгэхээр байгааг тэмдэглэж байна. Түүнчлэн тус маягтад буй мэдээллийн үнэн зөв байдлыг бие даан нэр дэвшигүүлэгч хариуцах хуулийн үүрэг байхгүй атал үүнийг маягтад тухайлан тусгасан байна.

2.3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт “Аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтыг тэмдэг дарж баталгаажуулан бие даан нэр дэвшигүүлэгчид энэ хуульд заасан нэр дэвшигүүлэх ажиллагаа явагдаж эхэлсэн өдрөөс олгоно.”, 31.4 дэх хэсэгт “Сонгогчдын гарын үсэг цуглуулах маягтад сонгогчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, иргэний бүртгэлийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хөдөлгөөнт, эсхүл суурин утасны дугаарыг тодорхой бичсэн байна.” гэж заасан нь бие даан нэр дэвшигүүлэх ажиллагааг журамласан шинжтэй, хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой асуудал байх тул тус хэсэг нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжгүй байна.

Гурав. Нэгтгэн дүгнэхэд

3.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшигүүлэгч тухайн тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг зуруулахаар хуульчилсан нь иргэний төрийн байгууллагад сонгогдох эрхийг хязгаарласан байх тул энэ талаарх үндэслэл, журам нь тодорхой хуульчлагдсан, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх шаардлагатай. Бие даан нэр дэвшигүүлэгчийн цуглуулсан гарын үсгийг түүвэрлэн тулгах, нягтлан шалгах үндэслэл, журам нь тодорхойгүйгээс эрх бүхий этгээд үзэмжээрээ хэрэгжүүлэх эрсдэлтэй. Энэ нь иргэн сонгогдох эрхээ эдлэх эсэхийг тодорхой, объектив шалгуураар бус, харин дур мэдэн шийдвэрлэх эрсдэлийг бий болгосон тул эрх зүйн тодорхой байдалд нийцэхгүй байна.

Гарын үсэг зуруулах тухай дээрх зохицуулалт нь хэт олон тооны нэр дэвшигч сонгуульд өрсөлдөн явцуу ашиг сонирхлын талбар болгохоос сэргийлэх, улмаар сонгох эрхийг баталгаатай эдлүүлэх, ардчилсан сонгуулийг шударга, үр нөлөөтэй явуулахад уялдаатай байгаа ч энэ



зорилгод хүрэхэд зайлшгүй, тэнцвэртэй биш байна. Тодруулбал, бие даан нэр дэвшүүлэгчид тавьж буй босго нь хүн ам, нийт сонгогчийн болон тухайн тойротг бүртгэгдсэн сонгогчийн тоотой харьцуулахад хэт өндөр, тохиромжгүй байгаа нь уг эрхийг хамгийн багаар хязгаарласан арга хэмжээ гэж үзэхээргүй байх тул зайлшгүй байх шалгуурыг хангаагүй байна. 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсгийг цуглуулахыг шаардаж, энэ босгыг агуулгын хувьд хангасан ч түүнд холбогдох зохицуулалтыг хэлбэрийн хувьд ялимгүй зөрчсөн тохиолдолд нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзаж сонгогдох эрхийг хасах үндэслэл болохоор хуульчилсан нь тэнцвэртэй байх шалгуурт нийцэхгүй гэж үзнэ.

Ялгаатай эрх зүйн байдал бүхий бие даан нэр дэвшүүлэгч болон нам, эвслээс нэр дэвшигч нарт харилцан адилгүй шаардлагыг хуульчлах боломжтой ч энэхүү ялгаа нь зөвтгөх үндэслэлтэй байх шаардлагатай. Гэтэл бие даан нэр дэвшүүлэгчид сонгогдох эрхээ эдлэхэд саад болохуйц хэт өндөр босго тогтоосон нь үндэслэлгүй байх тул тэгш байх эрх, ялгаварлан гадуурхаагүй байх зарчмыг зөрчсөн байна. Мөн бие даан нэр дэвшүүлэгчийн цуглуулсан гарын үсгийг түүвэрлэн тулгах, нягтлан шалгах үндэслэл, журмыг тодорхой хуульчлаагүй нь эрх зүйн адил субъектүүд болох бие даан нэр дэвшүүлэгч нарт зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандах нөхцөлийг үсгэжээ.

Төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох нь Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактаар хүлээн зөвшөөрөгдсэн үндсэн эрх. Дээр дурдсанчлан бие даан нэр дэвшүүлэгч сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд зайлшгүй бус, тэнцвэргүй хэт өндөр босго тогтоож холбогдох үндэслэл, журмыг тодорхой хуульчлаагүй нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн “үндэслэл бүхий бөгөөд нэр дэвшихэд саад болохгүй байх” зарчимд нийцэхгүй байна. Иймээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн бие даан нэр дэвшүүлэгч 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг зуруулах зохицуулалт нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт харшилсан байна.

3.2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг нь Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэг, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг зөрчсөн байх бөгөөд Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг нь бие даан нэр дэвшүүлэх ажиллагааг журамласан шинжтэй, хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой асуудал байх тул тус хэсэг нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжгүй байна.

3.3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд нийцээгүй хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, сонгуулийн төв байгууллагын шийдвэр, түүнчлэн өмнөх шийдвэрээ Цэц хүчингүй болгосон нь тэрхүү хууль, зарлиг, шийдвэр, гэрээний улмаас учирсан хор хохирол болон бусад үр дагаврын асуудлыг шийдвэрлэх шууд үндэслэл болохгүй. Гагцхүү Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл тогтоогдсон бол Цэцийн шийдвэрийг баримтлан хэргийг зохих хууль тогтоомжийн дагуу дахин хянаж болно.” гэж Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон байна (Цэцийн тогтоол, 2024, №02). Иймд Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлт гарсан цагаасаа хойш (ex nunc) үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай.

3.4. Үндсэн хуулийн цэцээс урьд нь Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчид тавих шаардлагатай холбоотой хэд хэдэн шийдвэр (Цэцийн дүгнэлт, 2008, №06; 2020, №03) гаргасан. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 11 дүгээр дүгнэлтээр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 2005 оны хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь энэ хуулийн 29.1-д заасан сонгогчийн дэмжлэгийг авахдаа аймагт тухайн тойргийн сум бүрийн, нийслэлд тухайн тойротг хамрагдсан хороо бүрийн сонгогчийн төлөөллийг оролцуулсан байна.” гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчөөгүй гэж үсэн ч энэ дүгнэлтээр бие даан нэр дэвшүүлэгч 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг зуруулах шаардлага Үндсэн хуульд нийцсэн эсэхийг шийдвэрлэгүй бөгөөд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг хөндөөгүй. Иймээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай 2019 оны хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэгт бие даан нэр дэвшүүлэгч 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг зуруулах болон түүнийг хэрэгжүүлэх журам Үндсэн хуульд нийцсэн эсэх тухай энэхүү маргаан нь Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 11 дүгээр дүгнэлтээр шийдвэрлэсэн асуудлаас ялгаатай болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий



хорооноос баталсан маятад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Арван дерөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ... -оор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчөөгүй байна.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.”, Арван дерөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ... -оор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг зөрчөөгүй байна.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшиүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маятад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.



5. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Г.БАЯСГАЛАН**

**ГИШҮҮД**

**Д.ГАНГАБААТАР**

**О.МӨНХСАЙХАН**

**Ц.ЦОЛМОН**

**Б.БОЛДБААТАР**



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2025 оны 02 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
 хот

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай  
хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн  
44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг  
зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 16.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан /илтгэгч/, Б.Болбаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн С.Номынбаясгалан, түүний өмгөөлөгч З.Тамир болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын холбогдох зохицуулалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

**Нэг. Монгол Улсын иргэн Ц.Монгол Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ:**

“Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт “Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг дараах хэлбэр, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгогчдод тараах эрхтэй:” гэж заан, дараагийн заалтуудаар сурталчилгааны материалын хэмжээ хязгаар, хориглох зүйлийг тогтоосон. Харин уг зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалыд тооцохгүй.” гэж, мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын

гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж хуульчилсан нь Улсын Их Хурлын гишүүнд давуу байдал олгож, тайлан гэх нэрээр сурталчилгаа хийх, давуу эрх эдлэх бүхий л боломжийг нээж өгсөн гэж үзэхээр байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг .... нийгмийн ... байдал, ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэж заасныг тус тус зөрчсөн, хуульд ийм заалт оруулснаараа Монгол Улсын Үндсэн хуулийн “эрх тэгш” байх зарчмыг зөрчиж байна. Энэ нь Улсын Их Хурлын гишүүн бус нэр дэвших сонирхол бүхий иргэний Үндсэн хуулиар хамгаалагдсан “аливаа ялгаварлалд өртөхгүй байх” эрхийг зөрчиж байна. Мөн Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад заасан төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхийг зөрчсөн, уг эрхэнд шууд бус хэлбэрээр нөлөөлж байна гэж үзэхээр байна.

Ялгаварлан гадуурхалт гэдэг нь хүн бүрд адил тэгш хандахгүй байх үйлдлийг хэлдэг. Мөн ялгаварлан гадуурхах гэдэг нь тухайн хүнд эрхээ эдлэх тэгш боломж олгохгүй байхыг хэлнэ. Үндэсний хууль тогтоомжоос гадна Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт, Алагчлахгүй байх (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) тухай 111 дүгээр конвенц зэрэг олон тунхаглал, олон улсын конвенцод ялгаварлан гадуурхахыг хориглосон байдаг. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах үндсэн зарчим, журмыг тодорхойлж, түүнтэй холбогдсон харилцааг зохицуулах, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахад оршино гэж тодорхойлжээ. Гэтэл энэ хуульд Улсын Их Хурлын гишүүнийг гишүүнийх нь хувьд тайлан тавих нэрээр сонгуулийн сурталчилгаа хийх давуу эрхийг хуульчилж, далд, халхавчилсан сурталчилгаа хийх боломжийг хуулиар олгосон гэж үзэхээр байна. Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын холбогдох зохицуулалтыг зөрчсөн болохыг тогтоолгохоор мэдээлэл гаргаж байна.” гэжээ.



**Хоёр. Монгол Улсын иргэн С.Номынбаясгалан Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ:**

“Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр баталсан Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйл (Сурталчилгаатай холбогдсон хязгаарлалт)-ийн 13.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно.” гэж заасан. Энэхүү хуульд дурдсан “зар сурталчилгаа” гэдгийг Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр баталсан Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад ““зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг,” ойлгоно гэж тайлбарлаж болохоор байна. Үүнээс гадна, дурдсан Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 13.1-д заасан хязгаарлалт нь Улсын Их Хурлын гишүүний болон Засгийн газрын гишүүний нийгэмд тустай үйл ажиллагааны сурталчилгаанд оролцоход хамаарахгүй.” гэж зааснаас үзвэл үндэсний хууль тогтоомжид ашиг олох зорилготой аж ахуйн үйл ажиллагаанд чиглэгдсэн зар сурталчилгаа болон ашгийн бус зорилготой сурталчилгааны талаар тодорхойлж, эдгээрийн агуулгыг ийнхүү “арилжааны болон арилжааны бус” гэх ерөнхий шинжээр ялгамжтай байдлаар зохицуулсан байна. Энэ нь нэг талаас Монгол Улсын Их Хурлын гишүүн ээлжит сонгуульд дэвшихээр болсон тохиолдолд хийж гүйцэтгэсэн ажлаа олон нийтэд тайлагнах нь тухайн нэр дэвшигчийн хувьд арилжааны бус зорилготой сурталчилгаанд, нэн ялангуяа сонгуулийн сурталчилгааны албан бус хэлбэрт хамаарах боломжтой юм. Нөгөө талаас сонгуульд нэр дэвшигчдийн хувьд гарсааны ижил бус ялгамжтай байдлыг бий болгон иргэн бүр хуулийн өмнө эрх тэгш байх, эрхэлсэн ажил, албан тушаалаар нь хэнийг ч ялгаварлаж үл болох тухай Үндсэн хуулийн суурь зарчмуудыг алдагдуулахын зэрэгцээ иргэний сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд нь анхнаасаа шударга бус (тэгш бус) байх хууль зүйн нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийн “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшигчдийн хувьд гарсааны ижил бус ялгамжтай байдлыг бий болгон иргэн бүр хуулийн өмнө эрх тэгш байх, эрхэлсэн ажил, албан тушаалаар нь хэнийг ч ялгаварлаж үл болох тухай Үндсэн хуулийн суурь зарчмуудыг алдагдуулахын зэрэгцээ иргэний сонгох, сонгогдох эрхээ эдлэхэд нь анхнаасаа шударга бус (тэгш бус) байх хууль зүйн нөхцөл боломжийг бүрдүүлсэн байна.

сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэсний “... үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн байх тул хүчингүй болгож өгнө үү.” гэсэн байна.

**Гурав. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд ирүүлсэн тайлбар, нэмэлтдээ:**

“1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн эсэх талаар,

Парламентат ёсны хувьд нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн тодорхой гурван чиг үүрэг байдаг нь “хууль тогтоо” - “төлөөлөх” - “хянан шалгах” чиг үүрэг бөгөөд манай улсын хувьд ч онопын энэхүү үзэл баримтлалыг Үндсэн хуульдаа тусгасан. Сонгох эрх нь хэн нэг этгээдэд өөрийгөө төлөөлөн эрх мэдэл хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх боломж буюу өөрийгөө төлөөлөн хууль тогтоох эрхийг шилжүүлэн өгч буй хэрэг мөн. Улсын Их Хурлын гишүүн нь Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу ард түмний элч бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтлах ёстай. Иймээс үйл ажиллагаандаа хувийн ашиг сонирхол биш нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримталж байгаа эсэхээ ардчилсан ёс, шударга ёсны зарчмын дагуу иргээдэд тайлагнах нь Улсын Их Хурлын гишүүний эрх гэхээсээ илүү Үндсэн хууль болон бусад хуулиар хүлээсэн үүрэг юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан. Иргэн төлөөлөгчөөрөө дамжуулан төрийг удирдах хэрэгт оролцоно гэдэг нь нийтлэг эрх ашгийг илэрхийлэх, хэрэгжүүлэх, хамгаалах эрхээ итгэмжлэгдсэн этгээдэд шилжүүлж, түүгээр дамжуулж оролцох эрхээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр юм. Энэ эрхийн хэрэгжилт өөрийн санал, санаачилгыг өөрийн сонгосон төлөөлөгчид уламжлах, түүний үйл ажиллагаанд хяналт тавих зэргээр хязгаарлагддаг. Өөрөөр хэлбэл, иргэд сонгуульд санал өгснөөр тэдний оролцоо дуусгавар болохгүй бөгөөд тэд өөрсдийг нь төлөөлөх үүрэг бүхий төлөөллийн байгууллага, төлөөлөгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, нөлөөлөх зэрэг олон хэлбэрийг ашиглах боломжтой юм.



Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болохоор, Хорин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаалахаар, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.26 дахь заалтад “сонгогчдод үйл ажиллагаагаа мэдээлэх.” бүрэн эрхтэй гэж заажээ. Улсын Их Хурлын гишүүн сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурал байгуулагдаж, шинэ сонгогдсон гишүүд тангарагаа өргөтөл өөрийн Үндсэн хуулиар заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх бөгөөд “төлөөлөх” бүрэн эрхээ буюу төлөөлөгч сонгогчдынхоо өмнө өөрсдийн үйлдлийн талаар байнгын яриа хэлэлцээгээр дамжуулан “тайлагнах” замаар хэрэгжүүлэх нь ардчиллын чухал шинж байдаг. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын сонгуулийн албан ёсны нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн сонгуульд дахин нэр дэвших магадлалтай этгээд болохынхоо хувьд “төлөөлөх” бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байх нь хариуцлага тайлгнналын тухай ойлголт, тухайн гишүүнийг төлөөлүүлэхээр сонгосон сонгогчийн эрхийг хөндсөн зохицуулалт болох юм.

Хариуцлага, тайлгннал нь тухайн үйл явдлын дараа зориуд анхаарсан, системтэй байдлаар “тайлан тавих”, түүнийг олон нийт юу гэж үзэж байгаагаа илэрхийлэх боломж олгох гэсэн утга агуулдаг. Сонгогч парламентын хэлэлцсэн гол асуудлаар тухайн төлөөлөгч ямар санал өгснийг мэдэх, ямар арга хэмжээ авсныг асууж лавлах сонирхол нь нэмэгдсээр байгаа, гишүүдийн хувьд саналаа яаж өгснөө нийтлүүлж, яагаад тийм санал өгснөө үндэслэлтэй тайлбарладаг байх нь улс төрийн хариуцлага тайлгнналын мөн чанар юм.

Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулахдаа үйлдэл, үйл ажиллагааны хувьд хуульд заасан хязгаарлалтыг нэгэн адил мөрдөх зохицуулалттай бөгөөд Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлын тайлангаа тараах, танилцуулах зорилгоор уулзалт хийж байгааг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэж заасан нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа аливаа хүн зөвхөн нийтлэг эрх ашиг, нийтийн ашиг тус, нийтийн сайн сайхны төлөө л тавьсан хууль ёсны хязгаарлалтаас бусад нөхцөлд хүний үндсэн эрх, эрх чөлөө нийтлэг, эрх зүйт хуулиар ижил тэгш хамгаалагдсан, тэрхүү хуулийг нь төв голч, шударга хууль сахиулагч хэрэгжүүлдэг, хараат бус шүүхийн нэгдмэл тогтолцоогоор хамгаалдаг болсон байхыг ойлгоно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлд ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын санаалыг татах зорилгоор зарим үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглохоор зохицуулсан бөгөөд энэ нь Улсын Их Хурлын гишүүний хувьд хийсэнажлынтайлангаа тараах болон сонгогчидтой уулзалт хийхэд нэгэн адил үйлчлэхээр зохицуулсан байна. Дээр дурдсан үйлдэл, үйл ажиллагааг Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсэгт “улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг” зөрчилд хамруулан холбогдох хариуцлага оногдуулахаар заасан.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг зөрчсөн эсэх талаар,

Ардчилсан нийгмийн гол шинж нь чөлөөт, шударга сонгууль бөгөөд нийгмийн шударга ёсыг эрхэмлэн дээдлэгч ард түмэн өөртөө үйлчлүүлэх, эрх чөлөө, эд хөрөнгөө хамгаалуулах сонирхлын үүднээс төрийг эмхэтгэн байгуулагдахыг дэмжин зөвшөөрдөг бөгөөд түүнийг эрх зүй, хууль тогтоомжоор зохицуулж ирсэн. Сонгууль бол улс төрийн үйл явцын чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үндсэн зорилго нь төр засгийн эрх барих байгууллага, тодорхой эрх мэдлийн албан тушаалтныг иргэдийн оролцоотойгоор санал хураалтаар шалгаруулан томилоход оршдог нэг талаас улс төрийн үзэгдэл, негөө талаас иргэдийн улс төрийн үндсэн эрхийг хангахад чиглэгддэг хууль зүйн шинжтэй ойлголт юм. Монгол Улс нь иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хууль, эрх зүйн хувьд Монгол Улсын Үндсэн хуулиараа баталгаажуулсан.

Сонгох эрх нь төрийн аливаа хэргийг шүүмжлэх, эсэргүүцэх, шийдвэр гаргахад оролцох, иргэний санал бодлыг зайлшгүй сонсох нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд хэрэв мэдээлэлгүй бол иргэн энэ эрхээ бодитойгоор эдэлж чадахгүйд хүрнэ. Энэ утгаараа Улсын Их Хурлын гишүүн



хийсэн ажлын тайлангаа танилцуулахдаа үйлдэл, үйл ажиллагааны хувьд дээр дурдсан хязгаарлалтыг нэгэн адил мөрдөх зохицуулалттай бөгөөд Улсын Их Хурлын гишүүнийхээ хувьд нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлын тайлангаа тараах, танилцуулах зорилгоор уулзалт хийж байгааг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад Монгол Улсын иргэн “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг авсан найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалzan хуулиар тогтооно;” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй, харин ч шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхийг баталгаажуулсан зохицуулалт гэж үзэж байна.

3.Мэдээлэл гаргагч нь Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Албан тушаалтан албан үүрэгт нь хамаарахаас бусад тохиолдолд аливаа зар сурталчилгаанд албаны нэр хүнд, албан тушаалын байдлаа ашиглан оролцохыг хориглоно.” гэж заасан зохицуулалтын “зар сурталчилгаа” гэдгийг Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д заасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг ойлгохоор тайлбарласан байна. Ингэхдээ уг “зар сурталчилгаа” арилжааны бус гэх ерөнхий шинжээр ялгамжтай байдлаар зохицуулсан бөгөөд Улсын Их Хурлын гишүүн хийж гүйцэтгэсэн ажлаа олон нийтэд тайлагнах нь тухайн нэр дэвшигчийн хувьд арилжааны бус зорилготой сурталчилгаанд, нэн ялангуяа сонгуулийн сурталчилгааны албан бус хэлбэрт хамаарах боломжтой гэж үзжээ.

Сонгуулийн сурталчилгаа гэдэг нь сонгуулийн өмнөх хугацаанд сонгогчдын дэмжлэгийг авахын тулд нэр дэвшигчид болон улс төрийн намуудын өрсөлдөөний хучин чармайлтыг ойлгодог. Нэр дэвшигчид сонгогчдод хүрэхийн тулд олон нийтийн өмнө гарах, цуглаан хийхээс эхлээд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах зэрэг олон арга техникийг ашигладаг бөгөөд сурталчилгааг ихэвчлэн сонгуулийн хуанлид заасан хугацаанд хийдэг бөгөөд энэ хугацаанд нэр дэвшигчид сурталчилгааны зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эсвэл олон нийтийн санд хандах хэлбэрээр онцгой үйлчилгээ үзүүлдэг.

Сурталчилгааны үеэр нэр дэвшигчид өөрсдийн мессежийг хүргэж, сонгогчдыг өөрсдийнхөө эсвэл намынхаа төлөө саналаа өгөхийг уриалдаг. Сонгуулийн эрх чөлөө, шударга байдалд нөлөөлөх хэд хэдэн сурталчилгааны асуудал бий. Үүнд сонгуулийн сурталчилгааны цаг хугацаа, сонгуулийн сурталчилгааг чөлөөтэй явуулах боломж, сонгуулийн сурталчилгааны явцад сонгуулийн байгууллагын ажилтнууд төвийг сахисан байх, оролцогчдын аюулгүй байдал, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүртээмж зэрэг багтана. Сонгуулийн сурталчилгаа нь иргэдийн сонгох, сонгогдох улс төрийн эрхтэй холбоотой асуудал учраас тусгайлан сонгуулийн хууль тогтоомжоор зохицуулж, сурталчилгаатай холбоотой харилцаанд ямар субъект оролцох, ямар эрх үүрэгтэй байх, ямар хориглолт, хязгаарлалттай байх, хариуцлагын тусгайлсан хэм хэмжээтэй байх зэргийг нарийвчлан зохицуулдаг. Энэ шинжээрээ бусад хэрэглэгчийн анхаарлыг татах “зар сурталчилгаа”-ны төрлүүдээс ялгаатай байдаг. Харин Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 13.1-д заасан хязгаарлалт нь Улсын Их Хурлын гишүүний болон Засгийн газрын гишүүний нийгэмд тустай үйл ажиллагааны сурталчилгаанд оролцоход хамаарахгүй.” гэж заасан нь сонгуулийн зар сурталчилгаанаас бусад аливаа төрлийн зар сурталчилгаанд Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүнд тавигдах хязгаарлалтыг илэрхийлсэн байна. Зар сурталчилгааны тухай хуульд заасан зар сурталчилгааны асуудал нь зохицуулах харилцаа, үйлчлэх хүрээгээрээ сонгуулийн сурталчилгаанаас ялгаатай бөгөөд Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулахыг зар сурталчилгаанд хамааруулан үзэх боломжгүй юм.

Дээр дурдсаныг үндэслэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтын холбогдох хэсгийг зөрчөөгүй гэж үзэн энэхүү тайлбарыг хүргүүлж байна.” гэжээ.

**Дөрөв. Мэдээллийг урьдчилан шалгах болон Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд бэлтгэх хүрээнд дараах баримт бичиг, шийдвэр, судалгаа, эх сурвалжтай танилцаж, холбогдох эрх бүхий этгээдээс тайлбар, лавлагага гаргуулан авсан болно:**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн холбогдох шийдвэр (Цэцийн магадлал, дүгнэлт, тогтоол, Цэцийн гишүүний тогтоол);

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо, “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.05.31, №1/427; “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг, 2025.02.11, №1/75;



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газар, “Мэдээлэл, баримт хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.09.04, №3/831;

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, “Баримт бичгийн хуулбар хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.05.29, №ТГ-02/906;

Цагдаагийн ерөнхий газар, “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.09.03, №01/675; 2025.02.10, №02/41;

Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөл, “Хариу хүргүүлэх тухай” албан бичиг, 2024.09.17, №01/1474;

Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Эрүүгийн хэргийн тусгай архив, Хариу албан бичиг, 2025.01.22, №48;

Нэгдсэн Үндэстний Байгууллага (цаашид “НҮБ” гэх)-ын Хүний эрхийн хороо, “Ерөнхий тайлбар: Төрийн үйл хэрэгт оролцох эрх, сонгуулийн эрх, төрийн алба хаших тэгш хүртээмжтэй байх эрх,” 1996, №25, CCPR/C/GC/25;

Олон улсын парламентын холбоо, “Парламент болон иргэд хооронд няйт холбоог хөгжүүлэх замаар ардчиллыг бататган бэхжүүлэх тухай,” Олон улсын парламентын 98 дугаар бага хурлын тогтоол, 1997.09.15;

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (цаашид “АСДҮОУХ” гэх), Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн Мэргэжлийн дүгнэлт, 2024.11.01;

Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Ардчилсан институт, хүний эрхийн газар (цаашид “ЕАБХАБ/АИХЭГ” гэх), “Монгол Улс: Улсын Их Хурлын сонгууль, 2016.06.29” тайлан; “Монгол Улс: Улсын Их Хурлын сонгууль, 2020.06.24” тайлан; “Монгол Улс: Улсын Их Хурлын сонгууль, 2024.06.28” эцсийн тайлан;

Ерөнхий тойм: Монгол Улсын Их Хурлын сонгууль 2024.

### ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Үндсэн хууль (цаашид “Үндсэн хууль” гэх)-ийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг цогцоор нь авч үзвэл иргэн бүр сонгуульд оролцох (сонгох, сонгогдох) тэгш боломжоор хангагдахаар байх бөгөөд үүнийг Үндсэн хуулиар хамгаалсан болохыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц (цаашид “Үндсэн хуулийн цэц” гэх)-ийн шийдвэрт удаа дараа тэмдэглэж байжээ (Цэцийн дүгнэлт 2007, №02; 2012, №02; 2019, №02; 2020, №11; 2024, №01; Цэцийн тогтоол 2007, №02; 2012, №03; 2022, №01). Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн

2020 оны 11 дүгээр дүгнэлтэд “Нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаа явуулах, мөрийн хөтөлбөрөө сонгогчид тайлбарлан таниулах нь хуулиар тогтоосон тодорхой хугацаанд явагддаг үйл ажиллагаа учир уг хугацаанд нэр дэвшигчдийг тэгш, шударгаар өрсөлдөх боломжоор хангаж, сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан эрх зүйн хамгаалалтыг бий болгох шаардлага үүсдэг бөгөөд энэхүү баталгааг сонгуулийн тухай хуулиар тогтоодог нь олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгдсөн байна.” гэжээ.

Сонгуульд оролцох тэгш боломж нь сонгуулийн өрсөлдөөний нөхцөл оролцогч бүрд шударгаар үйлчлэх, улмаар сонгох, сонгогдох эрхийг эдлүүлэх урьдаач нөхцөл болно. Учир нь сонгуульд оролцох аль нэг талд бусдаас давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр олгох нь сонгуульд шударгаар өрсөлдөх нөхцөлийг алдагдуулна. Иймээс сонгуульд оролцох тэгш боломжийг бүрдүүлж, холбогдох баталгааг хангах нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар төрийн үүрэг болно. Түүнчлэн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цугланаан хийх эрх чөлөө нь ардчилсан сонгууль явуулах үндэс болдог тул эдгээр эрх чөлөөг иргэн бүрд баталгаатай эдлүүлж, холбогдох хязгаарлалт нь тэгш үйлчилнэ.

Иргэн сонгуулийн жил эхэлснээс хойших хугацаанд сонгогдох эрхээ илүү идэвхтэй эдлэх магадлалтай тул энэ хугацаанд уг эрхээ эдлэх тэгш боломжоор хангагдах учиртай. Энэ хүрээнд сонгуульд нэр дэвших сонирхолтой иргэн, нэр дэвшигч, улс төрийн нам нь үзэл санаа, мөрийн хөтөлбөрөө сонгогчдод чөлөөтэй түгээх, өөрийгөө таниулах тэгш боломжтой байна. Тухайлбал, Монгол Улсын Их Хурал (цаашид “Улсын Их Хурал” гэх)-аас 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно.” гэж сонгуулийн сурталчилгааны хугацааг нийтлэг үйлчлэхээр заасан. Ийнхүү зөвшөөрснөөс бусад хугацаанд сурталчилгаа явуулахыг хориглох нь мөрийн хөтөлбөрөө танилцуулах, сонгогчидтой харилцах болон бусад үйл ажиллагаа явуулах тэгш боломжийг бүх нэр дэвшигч, намд олгох, сурталчилгааг хэт удаан үргэлжлүүлэх замаар зүй бус давуу байдал олж авахаас сэргийлэх, сонгуулийн зардлыг бууруулах, сонгогчдод нэр дэвшигчийн талаар мэдээлэл өгөх, ил тод байдлыг нэмэгдүүлэх, сонгуулийн сурталчилгааны үйл явцыг илүү тодорхой, олон нийтийн хяналттай болгоход чиглэдэг (АСДҮОУХ, 2024, х. 3-4).

Тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа



энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж, мөн хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь сонгуулийн жил эхэлснээс хойш сонгуулийн сурталчилгааны хугацаанаас өмнө Улсын Их Хурлын гишүүнд ажлын тайлангаа тараах, уулзалт хийх давуу байдлыг олгож, бусад иргэнд хориглосон агуулгыг илэрхийлж байх тул сонгуульд оролцох тэгш боломжийг хязгаарласан шинжтэй байна.

Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь тодорхой, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх зарчимд нийцэх шаардлагатай. Иймээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь эдгээр зарчимд нийцсэн эсэхээр Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтыг зөрчиж сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан эсэх нь тодорхойлогдоно.

#### Нэг. Эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэх

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим төдийгүй эрх зүйт төрийг өргөн агуулаар хамгаалдаг. Тухайлбал, хууль дээдлэх зарчмын дагуу үндсэн эрхийг хуулиас гадуур хязгаарлахыг хориглох бөгөөд үндсэн эрхэд тавих хязгаарлалтыг хуульд хэлбэрийн хувьд тусгаснаар энэ зарчим хангагдахгүй, харин түүний үндэслэл, журмыг тодорхой хуульчлах буюу эрх зүйн тодорхой байдлыг хангах шаардлагатай (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Өөрөөр хэлбэл, үндсэн эрхийг гагчхүү хуулиар хязгаарлах бөгөөд уг хязгаарлалт нь хоёрдмол утгагүй, тодорхой, үр дагаврыг урьдчилан таамаглаж, мэдсэнээр зан үйлээ нийцүүлэх боломжтой байдлаар хуульчилбал зохино (Цэцийн дүгнэлт, 2002, №02; 2020, №12; 2021, №02; Цэцийн тогтоол, 2002, №02). Иймээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь эрх зүйн тодорхой байдлыг хангасан эсэхийг шалгахад дараах үндэслэл тогтоогдож байна:

1.1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэг нь хуулиар зохицуулах шаардлагыг хэлбэрийн хувьд хангаж байгаа боловч эрх зүйн тодорхой байдалд нийцэхгүй байна. Тус хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт “Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна:” гээд 39.2.1 дэх заалтад

“сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод тараах;” гэж зохицуулжээ. Энэ заалтын дагуу хийсэн ажлын тайлангаа сонгогчдод тараах нь сонгуулийн сурталчилгааны материал тараахад хамаарахаар байх боловч Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө ийм тайлан сонгогчдод тараах нь тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийн дагуу сонгуулийн сурталчилгааны материал тараасанд тооцогодохооргүй байна. Хийсэн ажлын тайлан нь сонгуулийн сурталчилгааны материалаас ямар ялгаатай нь хуулийн зохицуулалтаас ойлгомжгүй байгаагаас Улсын Их Хурлын гишүүн тайлан тараах нэрээр сонгуулийн сурталчилгаа хийх боломжийг бүрдүүлжээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нэр дэвшүүлэх ажиллагааг санал авах өдрөөс 45 хоногийн өмнө эхлүүлж, долоо хоногийн хугацаанд дуусгана.” гэж нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх хугацааг заажээ. Гэтэл нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнөх хугацаанд Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвших эсэх нь тодорхойгүй байх атал энэхүү хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа” тарааж болохоор зохицуулжээ. Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихгүй тохиолдолд ийнхүү тайлангаа тараах эрхтэй эсэх нь эргэлзээтэй байна. Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн “нэр дэвшихээр бол” ажлын тайлан тараах нөхцөлийг тусгаснаас үзвэл тухайн тайлан нь сонгуульд нэр дэвшихэд зориулагдсан гэх утгыг илэрхийлж байх тул агуулгаараа сонгуулийн сурталчилгаанд огт хамаарахгүй гэж үзэх үндэслэлгүй юм. Хэдийгээр сонгуулийн сурталчилгааг тус хуулийн тодорхойлоогүй боловч үүнийг санал хураалтаас өмнөх хугацаанд сонгогчдын дэмжлэгийг авахад чиглэсэн нэр дэвшигч болон намын өрсөлдөөнт үйл ажиллагааг ойлгохоор байна. Нэр дэвшигч эсхүл нам өөрийн үзэл санаа, мөрийн хөтөлбөрийг сурталчлах, өөрийгөө таниулах замаар сонгогчдын дэмжлэгийг авахын төлөө сонгуулийн сурталчилгаа явуулдаг. Иймд Улсын Их Хурлын гишүүний тараах тайлан нь хийсэн ажлаараа сонгогчдод өөрийгөө таниулах, улмаар сурталчлах боломж олгож байгаа тул сонгуулийн сурталчилгааны шинжийг агуулж болох юм.

Улсын Их Хурлын гишүүний хийсэн ажлын тайланг сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх хүртэл тарааж болохоор заасан ч энэ тайланд ямар шаардлага тавих, ямар мэдээлэл тусгаж болох эсхүл болохгүй, сонгуулийн сурталчилгааны агуулга оруулж болох эсэх, түүнд хэн яж хяналт тавих нь тодорхой хуульчлагдаагүй байна. Урьд нь төстэй асуудлыг шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2020 оны 32 дугаар тогтоолд “тайлангийн хэвлэмэл материалд сонгуулийн сурталчилгааны агуулга бүхий мэдээлэл оруулсан эсэхэд холбогдох этгээд хяналт тавихтай холбоотой асуудал хийдэлтэй байхаас



гадна энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг нэмж хуульчлах шаардлага буйг үгүйсгэхгүй" гэж тэмдэглэжээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийн дагуу Улсын Их Хурлын гишүүний хийсэн ажлын тайланг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй гэж хуульчилсан тул сурталчилгааны материалд тавигдах шаардлагыг хангахгүй байхыг зөвшөөрсөн байна. Тухайлбал, тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1 дэх хэсэгт "Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг дараах хэлбэр, хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр сонгогчдод тараах эрхтэй:" гээд 41.1.1 дэх заалтад "хоёр хэвлэлийн хуудас сонин;", 41.1.2 дахь заалтад "хоёр хэвлэлийн хуудас сэтгүүл; ", 41.1.3 дахь заалтад "нэг хэвлэлийн хуудас ухуулах буюу зурагт хуудас." гэж заажээ. Гэтэл Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо (цаашид "Сонгуулийн ерөнхий хороо" гэх)-ны ирүүлсэн тайлбар (2024.05.31, №1/427)-т "Улсын Их Хурлын гишүүний хийсэн ажлын тайлангийн хэвлэлийн хэмжээнд тусгайлсан хязгаарлалт тоогоогоогүй бөгөөд энэхүү тайланг сурталчилгааны материалд тооцохгүй гэж хуульчилсан." гэжээ. Түүнчлэн Сонгуулийн ерөнхий хорооноос 2015 оны Сонгуулийн тухай хуулийн ажлын тайлан тараах тухай төстэй заалттай холбогдуулан "Улсын Их Хурлын гишүүн нь зөвхөн хийсэн ажлынхаа тайланг сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө тарааж болно. Харин сонгуулийн албан ёсны сурталчилгаа эхэлснээс хойш тараах ажлын тайлан нь Сонгуулийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.5-д заасан гурван хэвлэлийн хуудас сурталчилгааны материалын хэмжээнд багтсан байвал зохино." гэх агуулга бүхий лавлагааг тухайн үеийн Улсын Их Хурлын гишүүн, улс төрийн намд хүсэлтийнх нь дагуу хүргүүлж байжээ (2016.02.17, №40; 2016.05.24, №221; 2016.05.26, №232; 2016.09.29, №606). Эдгээр тайлбараас Улсын Их Хурлын гишүүний хийсэн ажлын тайлан нь сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэх хүртэл тараагдах ч тус хуульд заасан сонгуулийн сурталчилгааны материалын тавигдах шаардлагыг хангахгүй байж болох бөгөөд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхэлмэгц нэр дэвшигч болохын хувьд хуулийн шаардлага үйлчилж эхлэх агуулгатай гэж ойлгогдож байна.

Улсын Их Хурлын гишүүн бус иргэн нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө өөрийн хийсэн ажлын тайлангаа тараах нь сонгогчдын санал татах зорилгоор эд зүйл тараасанд эсхүл зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийсэнд тооцогдохоор байх боловч Улсын Их Хурлын гишүүн ийнхүү тайлан тараахыг уг хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгээр зөвшөөрсөн байна. Тус хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт "Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал авах өдрийг дуустал, нөхөн, ээлжит бус сонгуулийн тухайд сонгууль товлон зарласан

шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал аливаа этгээд өөрөө болон бусдаар дамжуулж сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно：“гээд мөн хэсгийн 48.1.1 дэх заалтад “мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх,” гэх зэргийг хоригложээ. Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн тайлбар (2024.05.31, №1/427)-т “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар сонгогчдод хийсэн ажлын тайлан тараах нь Үндсэн хуульд заасны дагуу бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа Улсын Их Хурлын гишүүнд хамаарах зохицуулалт бөгөөд гишүүн биш иргэн тайлан тараах нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1-т заасан сонгогчдын санал татах зорилгоор эд зүйл тараасан зөрчилд хамаарах боломжтой юм.” гэжээ. Түүнчлэн тус хуулийн 48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэгт “Сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно：“гээд тус хэсгийн 48.5.1 дэх заалтад “энэ хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;”, 48.5.2 дахь заалтад “зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;”-ийг тус тус хориглосон байна. Өмнө тайлбарласны дагуу ажлын тайлан нь сонгуулийн сурталчилгааны материалаас ямар ялгаатай нь тодорхойгүй тул Улсын Их Хурлын гишүүн бус иргэн нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө ажлын тайлангаа тараах нь агуулгын хувьд тус зүйлийн 48.5.2 дахь заалтын “зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх” зөрчилд хамаарах боломжтой байна.

Дээр дурдсан зөрчил нь нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тогтоогдсон бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах, нэр дэвшиүүлэх ажиллагаа эхэлсний дараа санал хураалтын дун гарахаас өмнө тогтоогдсон бол нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгох үр дагавартай байна. Учир нь тус хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.7 дахь заалтад “энэ хуулийн 48.1-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан болох нь хуульд заасны дагуу тогтоогдсон;” бол нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзана гэж, түүнчлэн мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсэгт “Нэр дэвшигч энэ хуулийн 35.3, 38.2, 48.1, 48.5.1, 48.5.2, 56.2-т заасныг зөрчсөн болох нь санал хураалтын дун гарахаас өмнө тогтоогдсон бол Сонгуулийн ерөнхий хороо тухайн нэр дэвшигчийг бүртгэсэн тухай шийдвэрээ хүчингүй болгож, нийтэд мэдээлнэ.” гэж заасан. Үүнийг Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн тайлбар (2024.05.31, №1/427)-т “... мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т заасан ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш сонгогчдын санал татах зорилгоор явуулахыг хориглосон бусад үйлдэл, үйл ажиллагаа гаргахыг хориглоно. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар хориглосон энэхүү үйлдэл, үйл ажиллагааг Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16-д зөрчилд тооцохоор хуульчилсан. Энэхүү зөрчил нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн



33.1.7, 75 дугаар зүйлд зааснаар нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах үндэслэл болох бөгөөд уг зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 7-д зааснаар цагдаагийн байгууллага шалгаж шүүх шийдвэрлэхээр хуульчилсан байна.” гэжээ.

Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 16 дахь хэсэгт “Хүн, хуулийн этгээд нь ээлжит сонгуулийн жил эхлэнээс хойш санал авах өдрийг дуустал, эсхүл нөхөн болон ээлжит бус сонгууль товлон зарласан шийдвэр гарснаас хойш санал авах өдрийг дуустал сонгогчдын саналыг татах зорилгоор” гээд 16.1 дэх заалтад “бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдсан, аливаа үйлчилгээг хөнгөлөлттэй болон төлбөргүйгээр үзүүлсэн;” бол гэж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтын дийлэнх хориглолтыг тусгасан ч тус заалт дахь “эд зүйл тараах” зөрчил тусгагдаагүй байна. Иймээс нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн бус иргэн хийсэн ажлын тайлангаа тараах нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил биш, харин Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалтад заасан сонгогчдын санал татах зорилгоор эд зүйл тараах зөрчилд хамаарахаар байна. Гэвч энэ зөрчлийг хянан шийдвэрлэх журам, эрх бүхий этгээд нь тодорхойгүй байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд Улсын Их Хурлын гишүүн бус, нэр дэвших сонирхол бүхий иргэн нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлын тайлангаа тараахыг илт зөвшөөрсөн заалт байхгүй байна. Гэхдээ Сонгуулийн ерөнхий хорооны дээрх тайлбар (2024.05.31, №1/427)-аас гадна тус хороонд ирсэн өргөдөл, гомдлын агуулга, түүний шийдвэрлэлтийн байдлаас үзэхэд мөн хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгээр Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тайлан тарааж болох боловч Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд ийм тайлан тараахыг хориглосон гэж ойлгдохоор байна. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн жилд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлээгүй байхад сонгогчид тайлан тараах нэрийдлээр сонгуулийн сурталчилгаа явуулах боломжийг бүрдүүлж байна гэх агуулгатай түрүүлж, гомдлыг Сонгуулийн ерөнхий хороонд ируулсэн байна. Тухайлбал, иргэн Г.Э-ээс “... сурталчилгааны хугацаа болоогүй байхад тараах материал сэтгүүл тараагаад байгаа өмнө нь УИХГ байсан ба одоо дахин нэр дэвшиж байгаа хүмүүст хариуцлага тооцно уу. Өмнө хийсэн ажлаа тайлагнамаар байдаг бол сонгуулийн жилийн өмнөх жил нь тайлагнаж хэрэгтэй.” гэх гомдлыг баримтын хамт хүргүүлжээ. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газраас уг хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсгийг дурдаж, Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө буюу 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрөөс өмнө хийсэн ажлын тайлангаа тарааж болно гэх

хариу (2024.05.24, №3/383)-г гомдол гаргагчид хүргүүлсэн байна. Хоёр гомдол (2024.05.17; 2024.05.27)-д Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн хэвлэмэл материал буюу тайлан тараасан гэх зэрэг агуулга тусгасан байна. Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газраас тэдгээрийг Цагдаагийн ерөнхий газрын зөрчлийн хэрэг бүртгэх албандаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтыг үндэслэн шилжүүлсэн байх (2024.05.22, №3/380; 2024.05.29, №3/408) бөгөөд нэг гомдлыг нь “зөрчлийн шинжгүй үндэслэлээр” хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна (2024.06.07, ЗХБ-39).

1.2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь хуулиар зохицуулах шаардлагыг хэлбэрийн хувьд хангаж байх боловч эрх зүйн тодорхой байдалд нийцэхгүй байна. Тус хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт “Сонгуулийн сурталчилгааг дараах арга, хэлбэрээр явуулна:” гээд 39.2.4 дэх заалтад “сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх;” гэжээ. Үүнээс үзвэл сонгогчидтой уулзалт хийх нь сонгуулийн сурталчилгааны арга, хэлбэрт багтах боловч тус хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгээр Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор нэр дэвшигүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийх уулзалтыг сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй байхаар зохицуулсан байна. Иймээс Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшигүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийхийг илт зөвшөөрсөн байх боловч ийм уулзалт хийхийг Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд зөвшөөрсөн эсэх нь тодорхойгүй байна.

Мөн хуулийн 48 дугаар зүйлд хууль бус сурталчилгааг хориглож, сонгогчдын саналыг татах зорилгоор явуулахыг хориглосон үйлдэл, үйл ажиллагааг жагсаажээ. Ийнхүү жагсаасан хориглоптод (мөн Зөрчлийн тухай хуульд) нэр дэвших сонирхолтой иргэн өөрийн хийсэн ажлын тайлангаа сонгогчдод танилцуулах зорилгоор уулзалт хийхийг илт хориглосон агуулга тусгагдаагүй байна. Гэвч тус хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт заасан шиг сонгогчидтой уулзалт хийхийг зөвшөөрсөн баталгаа Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд байхгүй учраас нэр дэвшигүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт нь тус хуулийн 48 дугаар зүйлийн 48.5.1 дэх заалтад “энэ хуульд зааснаас өөр арга, хэлбэрээр сонгуулийн сурталчилгаа хийх;” эсхүл мөн зүйлийн 48.5.2 дахь заалтад “зөвшөөрснөөс бусад хугацаанд сонгуулийн сурталчилгаа хийх;” үйлдэлд тооцогдох, улмаар нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах эсхүл нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгох эрсдэлийг бий болгосон байна.



Тус хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийн “Энэ хуульд заасан нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн ... энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэдэгт юуг хамааруулан үзэх нь тодорхойгүй байна. Энэ заалт “хуулиар хориглоогүй бол иргэнд зөвшөөрөх” зарчмыг хуульчлах зорилготой бол яагаад гагцхүү Улсын Их Хурлын гишүүнд зориулан тусгайлан заасан үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн жилд Улсын Их Хурлын гишүүн болон бусад этгээд сонгуулийн сурталчилгааны хугацаа эхлээгүй байхад сонгогчидтой уулзалт эсхүл бусад арга хэмжээ зохион байгуулж сурталчилгаа хийсэн гэх агуулгаар өргөдөл, гомдол Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлснийг эрх бүхий этгээдэд шилжүүлж, холбогдох хариуг өгчээ. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн биш ч Улсын Их Хурлын сонгуульд “нэр дэвшихээр горилж буй” гэх хоёр хүн “иргэдийн саналыг татах зорилгоор уулзалт зохион байгуулсан” гэх өргөдөл, гомдол (2024.05.17)-ыг Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газраас Цагдаагийн ерөнхий газрын зөрчлийн хэрэг бүртгэх албанад Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалтыг үндэслэн шилжүүлжээ (2024.05.22, №3/380). Энэ хоёр хүний нэг нь Засаг дарга байсан бөгөөд түүнд холбогдох гомдол, мэдээллийг шалгасан цагдаагийн албан хаагч нь тухайн Засаг дарга иргэдтэй уулzsаныг тогтоосон ч “энэ үйлдэл нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул” тухайн гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна (2024.06.07, ЗХБ-39).

Хоёр. Тохирсон байх зарчмыг хангасан эсэх

Тохирсон байх зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангах ёстой (Цэцийн дүгнэлт, 2024, №03; №04; 2025, №01; Цэцийн тогтоол, 2024, №02; №03). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь сонгуульд оролцох тэгш боломжийг хязгаарласан байх тул эдгээр шалгуурыг хангасан эсэхийг шалгахад дараах үндэслэл тогтоогдож байна:

2.1. Үндсэн эрхийн хязгаарлалт нь Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсэн хууль ёсны зорилготой байна (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Үндсэн хуулийн Оршилд Монголын ард түмэн бид “... эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. ...” гэж, Нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.” гэж, мөн

зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан. Иймээс ард түмний бүрэн эрхт байдлыг Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж тусгасан бөгөөд энэ зарчим нь төрийн бүх эрх мэдлийг ард түмнээс эхтэй байхыг шаарддаг. Өөрөөр хэлбэл, ардчилсан улсад төрийн эрх мэдлийн аливаа акт ард түмнээс үүдэлтэй байх бөгөөд иргэд төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд зохих ёсоор нөлөөлөх боломжоор хангагдах эрхтэй байна.

Ард түмний бүрэн эрхт байдлыг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж иргэний үндсэн эрхийн талаас нь бэхжүүлсэн бол сонгуулиар бүрдсэн Улсын Их Хурлаар уламжлан буюу төлөөллийн ардчиллаар хэрэгжүүлэх агуулгыг Үндсэн хуулийн Хорьдуугаар зүйл, Хорин нэгдүгээр зүйлд тусгасан. Улмаар Үндсэн хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэж эрх зүйн байдлыг нь тогтоосон.

Ардчилсан сонгуулиар бүрдсэн Улсын Их Хурал нь иргэдийг төлөөлж, хууль батлах, хуулийн биелэлтийг хянан шалгах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлдэг тул эдгээр бүрэн эрхийг хэрхэн хэрэгжүүлсэн тухай мэдээллээр иргэдийг хангах, ил тод байх шаардлагатай. Энэ хүрээнд Улсын Их Хурлын гишүүн ард түмний элчийн хувьд сонгогчидтой нягт холбоо, эгэх хариуцлагатай байх зохицуулалтыг хуульчлах боломжтой. Иймээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт ажлын тайлангаа тараах, сонгогчидтой уулзалт хийхийг зөвшөөрсөн нь Улсын Их Хурлын гишүүн сонгогчидтой нягт холбоо, эгэх хариуцлагатай байх гэсэн хууль ёсны зорилготой гэж үзэхээр байна.

Олон улсын парламентын холбооны 98 дугаар бага хурлын тогтоол (1997.09.15)-д парламент болон иргэдийн хооронд нягт холбоог хөгжүүлэх замаар ардчиллыг бататган бэхжүүлэх шаардлагыг онцолсон. Энэ хүрээнд Улсын Их Хурлын гишүүний сонгогчидтойгоо уулзалт, хэлэлцүүлэг хийхийг хууль ёсны гэж хүлээн зөвшөөрч, сонгогчдыг төрийн үйл хэрэгт татаан оролцуулах явдлыг дэмжих замаар энэ шаардлагыг хангана гэж үзэх боломжтой. Гэвч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүн өөрсдийн “хийсэн ажлын тайлангаа” “тараах”,



энэ тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой “уулзалт” хийх гэсэн зөвхөн нэг талын ажиллагааг тусгасан нь Олон улсын парламентын холбооны зөвлөсөн “уулзалт, хэлэлцүүлэг”-ээс ялгаатай байна.

Улсын Их Хурлын гишүүн иргэдээс сонгогдож төлөөлж байгаа тул бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлсэн талаараа тайлагнах нь зүйтэй хэмээн хууль тогтоогч үзэж ажлын тайлан тарааж болохоор зохицуулсан байна. Тодруулбал, ийм агуулгатай заалтыг анх хуульчлах үед буюу 2011 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн теслийг хэлэлцсэн Төрийн байгуулалтын байнгын хорооны тэмдэглэл (2011.11.29, х.13)-д “Улсын Их Хурлын гишүүн бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч гэдэг бол олон түмнээсээ сонгогдсон иргэдийн төлөөлөл байдаг. Тэгэхээр иргэдийнхээ мандатыг хэрэгжүүлэх ажлынхаа хүрээнд хийж байгаа учраас энэ заалт орж байгаа юм байна.” гэж тайлбарласан байна. Түүнчлэн Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбар (2024.09.10, №УИХ-03/2829)-таа “Улсын Их Хурлын гишүүн сонгуулийн үр дүнд ... Улсын Их Хурал байгуулагдаж, шинэ сонгогдсон гишүүд тангаргаа өргөтөл Үндсэн хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх бөгөөд “төлөөлөх” бүрэн эрхээ буюу төлөөлөгч сонгогчдынхоо өмнө өөрсдийн үйлдлийн талаар байнгын яриа хэлэлцээгээр дамжуулан “тайлагнах” замаар хэрэгжүүлэх нь ардчиллын чухал шинж байдаг. Өөрөөр хэлбэл, Улсын Их Хурлын сонгуулийн албан ёсны нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Хурлын гишүүн сонгуульд дахин нэр дэвших магадлалтай этгээд болохынхоо хувьд “төлөөлөх” бүрэн эрхээ хэрэгжүүлэхгүй байх нь хариуцлага тайлагналын тухай ойлголт, тухайн гишүүнийг төлөөлүүлэхээр сонгосон сонгогчийн эрхийг хөндсөн зохицуулалт болох юм.” гэсэн байна.

2.2. Үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгыг хэрэгжүүлэхэд үйлчлэх буюу чиглэсэн байхыг уялдаатай байх шалгуур шаардана (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгээр хийсэн ажлын тайлангаа тараах, сонгогчидтой уулзалт хийхийг Улсын Их Хурлын гишүүнд илт зөвшөөрсөн нь сонгогчидтой нягт холбоо, эгэх хариуцлагатай байх зорилгыг хангахад үйлчилж байх тул тус шалгуур хангагдаж байна.

2.3. Үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй байна. Тус зорилгод хүрэхийн тулд авч болох боломжит, үр дүнтэй арга хэмжээнүүдээс ижил үр дүнтэй боловч үндсэн эрхэд хамгийн бага халдсан арга хэмжээг нь сонгохыг энэ зарчим шаардана (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийн дагуу Улсын Их Хурлын

гишүүнд тайлан тараах, сонгогчидтой уулзалт хийхийг зөвшөөрсөн нь сонгогчидтой нягт холбоо, эгэх хариуцлагатай байхад чиглэж байх боловч энэ зорилгод хүрэхэд зайлшгүй байх шалгуурыг хангахгүй байна.

Дагнасан судалгаанаас үзэхэд сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэх хүртэл парламентын гишүүн хийсэн ажлын тайлангаа тараах, уул тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийх асуудлыг зохицуулах гурван загвар байх боломжтой байна. Эхний нь ийнхүү тайлан тараах, уулзалт хийхийг парламентын гишүүнд зөвшөөрөх, харин бусад иргэнд хориглох агуулгатай Монгол Улсын одоогийн загвар. Хоёр дахь нь хийсэн ажлын тайлангаа тараах, уул тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийхийг парламентын гишүүн болон бусад иргэний аль алинд нь сонгуулийн жилд зөвшөөрөх чүүнийг нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс тодорхой хугацааны өмнө хориглох загвар. Гурав дахь нь ийм тайлан тараах, уулзалт хийхийг парламентын гишүүн болон бусад иргэний аль алинд нь нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэх хүртэлх хугацаанд адилхан зөвшөөрөх загвар. Эдгээр гурван загвараас эхний буюу одоогийн загвар (Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг) нь ажлын тайлан тараах, түүнийгээ танилцуулах зорилгоор уулзалт хийх давуу байдлыг зөвхөн Улсын Их Хурлын гишүүнд олгосон учраас сонгуульд оролцох тэгш боломжийг хамгийн бага хязгаарласан арга хэмжээ биш байх тул зайлшгүй гэж үзэхгүй.

Зөвхөн Улсын Их Хурлын гишүүнд давуу байдал олгохгүйгээр хууль ёсны зорилгыг хангахад чиглэсэн бусад арга замаас үндсэн эрхэд илүү нийцсэнийг нь сонгон хэрэглэх шаардлагатай. Энэ талаар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэргэжлийн дүгнэлтэд “Парламентын гишүүн ард түмнийг төлөөлж гүйцэтгэсэн ажлын тайлангаа танилцуулахыг зөвшөөрөх нь үндэслэлтэй байж болох ч сонгогчийн санал татах үйл ажиллагааг тогтоосон сурталчилгааны хугацааны дотор явуулахаар хязгаарлах нь зүйтэй. Түүнчлэн ирээдүйд ард түмнийг төлөөлөх хүсэлтэй хүн ч өөрийн үзэл бодол, үйл ажиллагааг нийтэд танилцуулах адил боломжоор хангагдах хэрэгтэй. Энэ нь үзэл бодлтой байх, үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх, чөлөөтэй зорчих эрх чөлөөний хүрээнд баталгаажсан байдаг.” (АСДҮОУХ, 2024, х. 4) гэж тусгажээ.

2.4.Хууль ёсны зорилгыг хангаснаар хүрэх үр дүн болон хөндөгдж байгаа эрхийг хэрэгжүүлэх шаардлага хоорондын тэнцвэрийг хангана. Тодруулбал, тус зорилгод хүрэх цорын ганц арга нь хэт өндөр үнээр хэрэгжих тохиолдолд тухайн аргыг хууль ёсны байсан ч ашиглаж болохгүй (Цэцийн дүгнэлт, 2024, №03). Сонгуулийн жил эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн төдийгүй бусад иргэн хийсэн ажлын тайлангаа



тараах, уул тайлангаа танилцуулах зорилгоор уулзалт хийх болон хуулиар хориглоогүй бусад арга хэмжээ явуулах нь нээлттэй байна. Гэвч сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх хүртэл хугацаанд зөвхөн Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа тараах, уул тайлангаа танилцуулах зорилгоор уулзалт хийх давуу байдлыг бий болгосон нь ард түмний элчийн хувьд сонгогчидтой нягт холбоо, эгэх хариуцлагатай байх зорилгод үйлчлэх боломжтой боловч энэ зохицуулалт нь сонгуульд оролцох тэгш бус боломжийг бий болгожээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийн дагуу тайлан тараах, сонгогчидтой уулзалт хийхийг Улсын Их Хурлын гишүүнд зөвшөөрсөн ч Улсын Их Хурлын гишүүн бус иргэн яг адил байдлаар тайлан тараах, сонгогчидтой уулзах нь тус хуулийн зөрчилд тооцогдох, улмаар нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах эсхүл нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болох буюу сонгогдох эрхээ эдлэх боломжгүй болох ноцтой үр дагавартай зохицуулалт нь тэдгээрийн хооронд тэнцвэргүй байдал үүсгэж, шударгаар өрсөлдөх нөхцөлийг алдагдуулж байна. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэргэжлийн дүгнэлтэд тэмдэглэснээр "... парламентын гишүүн биш ч гэсэн сонгуульд нэр дэвших сонирхолтой бусад хүнд өөрийн тайлан, ололт амжилтаа танилцуулах боломж олгосон тэнцвэртэй зохицуулалтгүйгээр уг заалт нь одоогийн парламентын гишүүнд шударга бус давуу байдал олгосон гэж үзэж болно." (АСДҮОУХ, 2024, х. 7) Иймд Улсын Их Хурлын гишүүн ард түмний элч болохын хувьд үйл ажиллагаагаа тайлагнах нь зүй ёсны боловч үүний тулд сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулж, тодорхой этгээдэд давуу байдал олгож болохгүй тул тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь тэнцвэртэй байх шалгурт нийцэхгүй байна.

Гурав. Ялгаварлан гадуурхсан эсэх

Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар тэгш байдал нь төрөөс бүхий л үйл ажиллагаандаа баримтлах үндсэн зарчим юм. Нэгөө талаас Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэж хүн бүр эрх тэгш байх зарчмыг баталгаажуулсан. Тус зарчим нь дараах агуултыг илрэхийлнэ. Нэгд, хүн бүрийг эрх зүйн этгээд гэж хүлээн зөвшөөрч, хүний нэр төрийг нь хүндэлнэ (Цэцийн дүгнэлт, 2025, №01). Энэ нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... Хүн бүр эрх зүйн этгээд байна." гэж туссан. Хоёрт, хуулийн агуулга, хэрэгжилт, хэрэглээ эсхүл бусад үйл ажиллагаанд хэнийг ч дорд үзэж, ялгаварлан гадуурхаж болохгүй. Энэ утгыг Үндсэн хуулийн Арван

дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэж тодруулсан бөгөөд энд дурдсан эсхүл дурдагдаагүй шинж (хөгжлийн бэрхшээл зэрэг)-ээр нь ялгаварлан гадуурхаж болохгүй (Цэцийн дүгнэлт, 2017, №07). Гуравт, хүн бүр эрхийнхээ хувьд тэгш байх бөгөөд үүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн болон бусад арга хэмжээг төрөөс авна. Тухайлбал, хүйс үл хамааран тэгш эрх эдлэхийг Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11 дэх заалтад “улс тэр, эдийн засаг, нийгэм сөёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;” гэж тусгайлан заажээ. Дөрөвт, ялгаварлан гадуурхахад хүргэх шалтгаан болсон ужиг нөхцөлийг арилгах, бууруулах зорилгоор хүн амын тодорхой хэсэгт давуу хандсан тусгай арга хэмжээ авах нь эрх тэгш байх зарчмыг хөндөхгүй. Тодруулбал, ийм нөхцөлийн улмаас хүний эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлж чадахгүй байгаа хүмүүст давуу байдал олгож болох бөгөөд зорилго нь биелмэгц тус арга хэмжээг зогсоно. Тавд, үндсэн эрхийг эдлүүлэх болон бусад хүрээнд хүмүүст дур мэдэн буюу зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандахыг хориглоно. Гэхдээ энэ зарчим нь хүмүүст дандаа адил хандах утгагүй бөгөөд зохих үндэслэлээр ялгаатай хандах, ангилал үүсгэхийг зөвшөөрнө.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгээр хийсэн ажлын тайлангаа танилцуулах, уулзалт хийхийг Улсын Их Хурлын гишүүнд илт зөвшөөрч, бусад иргэнд ийнхүү зөвшөөрөөгүй нь өмнө тайлбарласанчлан эрх зүйн тодорхой байдлыг хангагүй төдийгүй хууль ёсны зорилгод хүрэхэд зайлшгүй бус, тэнцвэргүй байх тул Улсын Их Хурлын гишүүнд бусад иргэнээс илүү давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр олгож, ялгаварлан гадуурхсан шинжтэй байна. Сонгуулийн жилд сонгуульд оролцохтой холбогдуулан иргэдэд зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандаж болохгүй. Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элч болохын хувьд бусад этгээдээс эрх зүйн байдлын хувьд ялгаатай субъект мөн боловч сонгуулийн жил эхэлснээр нэр дэвшихээр бол нэр дэвших сонирхол бүхий бусад иргэнтэй адил субъект тул хуулийн хязгаарлалт, эрх, үүрэг нэгэн адил үйлчилнэ. Иймээс сонгуулийн жилд сонгуулийн сурталчилгааны хугацаанаас өмнө буюу нэр дэвшигүүлэх ажиллагааг эхлэх хүртэл Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах, уулзалт хийхийг зөвшөөрч байгаа бол үүнтэй адил үйл ажиллагааг Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд мөн зөвшөөрч, нэр дэвшихээр төлөвлөж байгаа бүх иргэнд сонгуульд оролцох тэгш боломж олгох учиртай.



Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно." гэж заасан. Олныг төлөөлөх аргыг хэрэглэх хүрээнд нэр дэвшигч нь өөрийгөө болон хувийн амжилтадаа нийтэд таниулах замаар сонгогчдын дэмжлэг авах хэрэгцээ хувь тэнцүүлэн төлөөлөх аргыг хэрэглэж байгаагаас илүү өндөр байдаг тул өөрийгөө таниулах тэгш боломжийг олгох шаардлагатай байдаг. Иймээс уг хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь сонгуулийн тойротгт нэр дэвшигч сонирхол бүхий Улсын Их Хурлын гишүүн болон бусад иргэний хооронд ажлаа тайлагнах замаар өөрийгөө таниулах тэгш бус боломжийг улам нэмэгдүүлэхээр байна.

Улсын Их Хурлаас 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсэгт "Гишүүн үйл ажиллагааныхаа талаар тойргийнхоо сонгогчдод мэдээлэх, сурталчлах зардал болон дотоод хэвлэл захиалгын зарим төлбөрийг улсын төсвөөс санхүүжүүлнэ." гэж зохицуулж байсан. 2024 оны 5 дугаар сарын 16-ны өдөр батлагдаж, одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Гишүүн дараах бүрэн эрхтэй." гээд 8.1.26 дахь заалтад "сонгогчдод үйл ажиллагаагаа мэдээлэх." гэж заасан. Үүнээс үзвэл Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа хэвлэх, сонгогчдод тараах, танилцуулах зорилгоор уулзалт хийх, хуулиар хориглоогүй бусад арга хэмжээ явуулах зэргийг Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд хамааруулах тохиолдолд улсын төсвийн санхүүжилтийг хэрэглэж болохоор байна. Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа тараах нь нэг талаас өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлж, түүнийгээ тайлагнаж байгаа хэлбэр гэж үзэж болох ч сонгуулийн жилд энэ үйл ажиллагааг сонгуулийн сурталчилгааны нэг хэсэг гэж тооцох, сонгуулийн сурталчилгаатай холбоотой хэм хэмжээ, тэр дундаа зардлын болон ил тод байдлын зохицуулалтад нийцүүлбэл зохино. Учир нь сонгуулийн сурталчилгааны хэм хэмжээ одоогийн парламентын гишүүн эсэхээс үл хамааран ижил үйл ажиллагаа явуулж байгаа бүх хүнд болон бүх үед адил үйлчлэх хэрэгтэй (АСДҮОУХ, 2024, х. 8).

Дөрөв. Олон улсын эрх зүй ба сайн туршлага

4.1. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлд заасны дагуу Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил дагаж мөрднө. Иймээс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын

Пакт (цаашид “Пакт” гэх)-аар хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох төдийгүй төрийн алба хаших эрх нь олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ бөгөөд эдгээр эрхийг баталгаатай эдлүүлэх нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг мөн (Цэцийн дүгнэлт, 2025, №01). Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр төрийг удирдах хэрэгт шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.”, 2 дахь хэсэгт “Хүн бүр улсдаа төрийн алба хаших тэгш эрхтэй.”, 3 дахь хэсэгт “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно.” гэж тус тус заажээ. Түүнчлэн Пактын 25 дугаар зүйлд зааснаар иргэн бүр (а) “төрийн үйл хэрэгт шууд болон чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох;”, (б) “сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтей илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох;”, (с) “тэгш эрхийн ерөнхий нөхцөлтэйгээр улсдаа төрийн алба хаших.” эрх, боломжийг аливаа ялгаварлан гадуурхал, үндэслэлгүй хязгаарлалтгүйгээр эдэлнэ.

1996 онд НҮБ-ын Хүний эрхийн хорооноос Пактын 25 дугаар зүйлээр хамгаалсан эрхийн тухай 25 дугаар Ерөнхий тайлбарыг гаргасан. Энэхүү тайлбар (догол 8)-т “Иргэд өөрсдийн төлөөлөгчидтэйгөө нийтийн мэтгэлцээн, харилцан ярианд оролцож эсхүл өөрсдөө зохион байгуулалтад орж нөлөөлөл үзүүлэх замаар төрийн үйл хэрэгт оролцож болно. Үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг баталгаажуулах нь энэхүү оролцоог хангахад дэмжлэг болно” гэдгийт тодруулсан байна. Мөн үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаан хийх эрх чөлөө нь сонгох эрхээ үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөл тул бүрэн хамгаалагдах ёстой (Ерөнхий тайлбар, №25, догол 12).

“Иргэн, нэр дэвшигч, сонгогдсон төлөөлөгч нар хоорондоо нийтийн болон улс төрийн аливаа асуудлаар мэдээлэл, үзэл санаагаа чөлөөтэй солилцох нь Пактын 25 дугаар зүйлээр хамгаалсан эрхийг бүрэн эдлүүлэхэд нэн чухал. Энэ нь нийтийн асуудлаарх санал бодлыг цагдан хяналт, хориг саадгүйгээр түгээх, нийтийн үзэл бодлыг мэдээлэлжүүлэх чадавх бүхий чөлөөт хэвлэл, мэдээллийн бусад хэрэгсэлтэй байх утгыг агуулна. Энэ нь Пактын 19, 21, 22 дугаар зүйлээр баталгаажсан эрхийг, үүний дотор дангаараа эсхүл улс төрийн нам, бусад байгууллагаар дамжуулан улс төрийн үйл ажиллагаанд оролцох, нийтийн асуудлаар мэтгэлцэх, тайван



жагсаал, уулзалт зохион байгуулах, шүүмжлэх, эсэргүүцэх, улс төрийн материал хэвлэн нийтлэх, сонгуулийн сурталчилгаа явуулах, улс төрийн үзэл санаагаа сурталчлах эрх чөлөөг хүндэтгэж, бүрэн эдлүүлэхийг шаардана.” (Ерөнхий тайлбар, №25, дого 25)

Сонгуульд нэр дэвших эрхэд тавих аливаа хязгаарлалт нь үндэслэл бүхий, объектив шалгуураар зөвтгөгдөхүйц байх бөгөөд нэр дэвшиүүлэхтэй холбоотой нөхцөл нь үндэслэл бүхий, ялгаварлан гадуурхаагүй байна (Ерөнхий тайлбар, №25, дого 15, 16). Түүнчлэн Пактын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү Пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон харьялалдаа байгаа бүх хүний энэхүү Пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, хөрөнгө чинээ, төрсөн буюу бусад байдлаар ялгаварлан гадуурхахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй.” гэжээ.

Иймд үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хүндэтгэж, бүрэн эдлүүлэх, ялангуяа иргэн, нэр дэвшигч, сонгогдсон төлөөлөгч нар хоорондоо нийтийн болон улс төрийн аливаа асуудлаар мэдээлэл, үзэл санаагаа чөлөөтэй солилцох боломжтой байх нь Пактын 25 дугаар зүйлд заасан сонгох, сонгогдох эрхийг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөл мөн. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа тараах, сонгогчидтой уулзалт хийхийг зөвшөөрч, тус хуулийн холбогдох бусад заалтаар адил үйл ажиллагааг иргэнд хориглосон гэж үзэхээр зохицуулсан нь Улсын Их Хурлын гишүүн бус иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг, үүний дотор “улс төрийн материал хэвлэн нийтлэх, сонгуулийн сурталчилгаа явуулах, улс төрийн үзэл санаагаа сурталчлах” эрх чөлөөг хязгаарласан байна. Өмнө дурдсанчлан энэхүү хязгаарлалт нь Улсын Их Хурлын гишүүнд бусад иргэнээс илүү давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр бий болгосон тул ялгаварлан гадуурхсан шинжтэй байна.

4.2.Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгээс Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэргэжлийн дүгнэлтэд сонгуулийн сурталчилгааны хугацаанаас өмнө ажлын тайлан тараах, сонгогчидтой уулзалт хийх давуу байдлыг парламентын гишүүнд хуулиар олгосон эсэхийг ардчилсан төлөвтэй 80 улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид тулгуурлан судлаад Монгол Улстай адил Улсын Их Хурлын гишүүнд ийм давуу байдал шууд олгосон зохицуулалттай улс байгаагүй гэж үзжээ. Харин Бүгд Найрамдах Солонгос Улсад Үндэсний Ассамблейн гишүүн “мэдээлэл өгөх уулзалт, бичгээр гаргасан тайлан (хэвлэмэл материал, дуу бичлэг, видео бичлэг, компьютержсон

мэдээлэл зэрэг), интернэт, мессеж эсхүл дуудлага хийсэн хүн болон хүлээн авагчийн хооронд шууд утсаар ярьсан яриа, мэндчилгээний үг"-эр дамжуулан парламентын үйл ажиллагааны талаар сонгогчдод тайлагнахыг хуулиар зөвшөөрдөг боловч сонгуулийн өдрөөс өмнөх 90 хоногийн хугацаанд ийнхүү тайлагнахыг хязгаарладаг байна.

Харьцуулан судалсан улсуудад парламентын гишүүний хувьд сонгуулийн сурталчилгаатай холбоотой нэмэлт хориглолтыг хуульчлах замаар сонгуульд оролцох тэгш боломжоор хангах, мөн үзэл бодлоо илэрхийлэх болон бусад эрх чөлөөнд тавих хязгаарлалт нь парламентын гишүүн болон бусад иргэнд нийтлэг үйлчлэх чиг хандлага ажиглагдаж байна. Тодруулбал, Бүгд Найрамдах Франц Улсад сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнөх зургаан сарын турш хэвлэл мэдээллийн хэрэгслээр төлбөртэй сурталчилгаа явуулах замаар сонгуулийн сурталчилгаа хийхийг хориглодог. Түүнчлэн Данийн Хаант Улс, Шинэ Зеланд Улс, Бүгд Найрамдах Косово Улсад парламентын гишүүн юу хийж болох, болохгүйг тодорхой тусгасан байдаг. Данийн Хаант Улсад телевизээр сурталчилгаа хийхийг парламентын гишүүнд хориглодог бол Шинэ Зеланд Улсад парламентын гишүүний зөвхөн "холбоо барих мэдээллийг" "сонгуулийн сурталчилгаа" гэсэн тодорхойлолтоос хасаж үздэг. Бүгд Найрамдах Косово Улс нь сонгогдсон болон томилогдсон бүх албан тушаалтныг сонгогчийн санал татах зорилгоор албан тушаалаа эсхүл түүний аливаа нөөцийг ашиглахыг хориглодог. Зарим улсад төрийн албан тушаалтан өөрийн албан тушаалаа ашиглах замаар давуу байдал олж авахыг хориглодог. Тухайлбал, Бүгд Найрамдах Энэтхэг Улс сайдын албан тушаалыг давхар хашиж байгаа парламентын гишүүнд албан айлчлал (уулзалт)-аа сонгуулийн сурталчилгаатай хослуулахыг, албаны техник, боловсон хүчийг ашиглахыг тус тус хориглосон байна. Мөн Бүгд Найрамдах Сенегал Улсад сонгуулийн сурталчилгааны албан ёсны хугацаа эхлэхээс 30 хоногийн өмнө төрийн албан тушаалтан хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдэгдэл гаргах, айлчлал (уулзалт) хийх, төрийн эсхүл хувийн байгууллагаас төрийн өмчийг ашиглах зэргээр "далд сурталчилгаа" хийхийг хуулиар хориглодог ажээ.

Тав. Үндэсний хууль тогтоомжийн тухайд

5.1. Түүхчлэн авч үзвэл Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд хийсэн ажлын тайлангаа сонгогчдод тараахыг тусгайлан зөвшөөрсэн зохицуулалт холбогдох хуульд тусч ирсэн байна. Тодруулбал, Улсын Их Хурлаас 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 35 дугаар зүйлийн 35.19 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүн, бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч бүрэн эрхийнхээ хугацаанд



сонгуулийн мөрийн хөтөлбөрийнхөө хүрээнд хийсэн ажлын тайлангаа иргэд, сонгогчдод сонин, сэтгүүл болон бусад хэвлэмэлхэлбэрээр хүргүүлэх нь энэ хуулийн 35.18-д үл хамаарна.” гэж Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа хүргүүлэх эрхийг анх тусгайлан хуульчилж байсан. Тус хуулийн 35 дугаар зүйлийн 35.18 дахь хэсэгт “Нам, эвсэл, нэр дэвшигч болон нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага, түүний ажилтан, нэр дэвшигчийн шадар туслагч, ухуулагчаас сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно:” гээд 35.18.1-35.18.18-д хориглосон үйлдэл, үйл ажиллагааг жагсаасан байжээ.

Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр баталсан Сонгуулийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.13 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч, орон нутгийн хурлын төлөөлөгч нэр дэвшиж байгаа тохиолдолд тэдгээрийн хийсэн ажлын тайлан сонгуулийн сурталчилгааны материалын хэмжээнд тооцогдохгүй.” гэж зохицуулж байжээ. Энэ заалтыг ЕАБХАБ/АИХЭГ-ын 2016 оны тайлан (х.15)-д “хуулийн хүрээний зарим заалтаар сонгуульт албан тушаал хашиж буй хүмүүсийн өөрийн ололт амжилтыг сурталчилсан материалыг сонгуулийн сурталчилгааны материал гэж үзэхгүй байсан нь сонгуульд дахин өрсөлдж байсан УИХ-ын гишүүдэд ашигтайгаар нөлөөлж байв. Мөн жижиг намууд болон улс төрд шинээр орогсдод ашиггүй нөхцөл бүрдүүлж буй хуулийн нэмэлт заалтууд байна.” гэж дүгнэсэн байдал.

5.2. Сонгуулийн тухай хууль (2015)-ийн 77 дугаар зүйлийн 77.13 дахь хэсгийн зохицуулалт нь 2019 онд батлагдаж, одоо хучин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт агуулгаараа туссан байна. Харин Улсын Их Хурлын гишүүн тайлан танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийх, энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ явуулах тусгайлсан зохицуулалт нь 2019 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт анх удаа тусжээ. Эдгээр зохицуулалт сүүлийн хоёр удаагийн Улсын Их Хурлын ээлжит сонгуулиар хэрхэн хэрэгжсэн талаар олон улсын болон дотоодын тайландаа тэмдэглэжээ. Тухайлбал, ЕАБХАБ/АИХЭГ-ын 2020 оны тайлан (х.2)-д “зарим хүмүүс сонгуулийн сурталчилгааны хугацаа хэт зохицуулалттай, өргөн уудам газар нутгийг хамарсан сурталчилгаа хийх хугацаа богино, цахим хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр худал мэдээлэл тараах, төрийн нөөцийг урвуулан ашигласан гэх зэрэгтэй холбоотой санаа зовниж байгаагаа илэрхийлжээ.” гэж ерөнхийд нь дурдсан байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн ажиглалтын талаарх ЕАБХАБ/АИХЭГ-ын эцсийн тайлан (х.15)-д “Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор 6 дугаар сарын 10-ны өдөр буюу

сонгуулийн өдрөөс 18 хоногийн өмнө эхэлж, 24 цагийн өмнө дууссан. Нэр дэвшихээр горилогчид албан ёсны сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө сурталчилгаа явуулахыг хуулиар хориглодог. Гэсэн хэдий ч, одоогийн УИХ-ын гишүүд дахин нэр дэвшихийг зорьж буй, нэр дэвшигчээр бүртгүүлэх үйл явц эхэлсэн эсэхээс үл хамааран сонгогдсон төлөөлөгчийн хувиар өөрсдийгөө сурталчилж болно. АИХЭГ-ын САХ-ны уулзсан маш олон хүн хуулиар зөвшөөрсөн тул одоогийн УИХ-ын гишүүд, төрийн өндөр албан тушаалтнууд сонгууль болохоос өмнө хэдэн сарын турш идэвхтэй кампанит ажил явуулж байсан талаар мэдэгдсэн юм. ... Сонгуулийн кампанит ажил зохион байгуулах эрх зүйн орчин хэт хязгаарласан байдлыг бууруулах, сонгуулийн албан ёсны сурталчилгааны хугацаа, түүнээс өмнөх цаг үед бүх өрсөлдөгчид сурталчилгаа явуулах ижил тэгш нөхцөлөөр хангаж хуульд өөрчлөлт оруулах нь зүйтэй. Ерөнхийдөө өрсөлдөгчид чөлөөтэй, хөндлөнгийн оролцоогүйгээр кампанит ажил явуулсан хэдий ч, кампанит ажил тоглох тэгш бололцоогоор дутагдаж байв.” гэжээ. Түүнчлэн иргэний нийгмийн ажиглалтад тулгуурлан боловсруулсан “Ерөнхий тойм: Монгол Улсын Их Хурлын сонгууль 2024” (х.10)-д “Улсын Их Хурлын гишүүд сонгогчдодо ажлаа тайлагнах нь зүй ёсны асуудал боловч хуулийн дээрх заалтууд нь сонгуулийн жил сонгогдсон гишүүдэд давуу тал олгон тэгш гараанаас өрсөлдөх нөхцөлийг дордуулаад зогсохгүй сонгуулийн жил төрийн эх үүсвэрийг улс төрийн сурталчилгааны зорилгоор ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна.” гэжээ. Эдгээр эх сурвалжаас үзэхэд уг хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгээр Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлынхаа тайлан тараах, уг тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийхийг илт зөвшөөрч, харин Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд ийнхүү зөвшөөрөөгүй байна. Эдгээр зохицуулалт нь тодорхой, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх зарчмыг хангахгүй байх тул иргэний сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан байна.

Зургаа. Нэгтгэн дүгнэхэд

6.1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгээр Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлынхаа тайлан тараах, уг тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийхийг илт зөвшөөрч, харин Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд ийнхүү зөвшөөрөөгүй байна. Эдгээр зохицуулалт нь тодорхой, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх зарчмыг хангахгүй байх тул иргэний сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан байна.

Нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн ажлын тайлан тараах, уг тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийх давуу байдлыг олгосон байх бөгөөд ийм боломжийг бусад иргэнд зөвшөөрсөн эсэх нь хуулийн зохицуулалтаас ойлгомжгүй байна. Мөн Улсын Их Хурлын гишүүний хийсэн ажлын тайланд ямар шаардлага



тавих, ямар мэдээлэл тусгаж болох эсхүл болохгүй, сонгуулийн сурталчилгааны агуулга оруулж болох эсэх, түүнд хэн яж хяналт тавих нь тодорхой хуульчлагдаагүй байна. Тус зохицуулалтад Улсын Их Хурлын гишүүн “нэр дэвшихээр бол” ажлын тайлан тараах нөхцөлийг тусгасан бөгөөд ажлын тайлан болон сурталчилгааны материал хоорондын ялгааг тодорхойлоогүй учраас ийм тайлан тараах нэрээр сонгуулийн сурталчилгаа хийх эрсдэлийг үүсгэжээ. Иймээс эрх зүйн тодорхой байдал хангагдсан гэж үзэх үндэслэлгүй юм.

Улсын Их Хурлын гишүүнд тайлан тараах, уулзалт хийх давуу байдал олгосон нь сонгогчидтой нягт холбоо, эгэх хариуцлагатай байх хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай байх боловч адил байдлаар тайлан тараах, уулзалт хийхийг Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд илт зөвшөөрөөгүй учраас сонгуульд оролцох тэгш боломжид хамгийн бага хязгаарласан арга зам гэж үзэхгүй тул зайлшгүй байх шалгуурт нийцээгүй байна. Түүнчлэн маргаан бүхий зохицуулалт нь сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсны зэрэгцээ Улсын Их Хурлын гишүүн бус иргэн адил байдлаар тайлан тараах, сонгогчидтой уулзах нь сонгогдох эрхээ эдлэх боломжгүй болох (нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах эсхүл нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгох) ноцтой үр дагавар үүсгэх эрсдэлтэй байх тул тэнцвэргүй байна.

Нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа тараах, тайлангаа танилцуулах зорилгоор уулзалт хийх замаар өөрийгөө сонгогчдод таниулах давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр бий болгосон байх тул ялгavarлан гадуурхсан шинжтэй байна. Учир нь Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элч болохын хувьд бусад этгээдээс эрх зүйн байдлын хувьд ялгаатай субъект мөн боловч сонгуулийн жил эхэлснээр нэр дэвшихээр бол нэр дэвших сонирхол бүхий бусад иргэнтэй адил эрх зүйн байдалтай гэж үзэх тул сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн хязгаарлалт, эрх, үүрэг нь нэгэн адил үйлчилнэ.

Иймд тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь сурталчилгааны бус хугацаанд сонгогчдод ажлын тайлан тараах, уулзалт хийх давуу байдлыг Улсын Их Хурлын гишүүнд зохих үндэслэлгүйгээр бий болгож, бусад иргэний сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан байх тул Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаал ...-аар нь ялгavarлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх

заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэж заасныг зөрчсөн байна.

6.2.НҮБ-ын Хүний эрхийн хорооны 25 дугаар Ерөнхий тайлбарт зааснаар иргэн, нэр дэвшигч, сонгогдсон төлөөлөгч нар хоорондоо нийтийн болон улс төрийн аливаа асуудлаар мэдээлэл, үзэл санаагаа чөлөөтэй солилцох боломжтой байх нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 25 дугаар зүйлд заасан сонгох, сонгогдох эрхийг баталгаатай эдлэх урьдач нехцөл болно. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь Пактаар хамгаалагдсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг, үүний дотор “улс төрийн материал хэвлэн нийтлэх, сонгуулийн сурталчилгаа явуулах, улс төрийн үзэл санаагаа сурталчлах” эрх чөлөөг хязгаарласан байх ч Улсын Их Хурлын гишүүнд бусад иргэнээс илүү давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр бий болгосон нь Пактын 25 дугаар зүйлд заасан эрх, боломжийг ялгаварлан гадуурхалгүйгээр эдлүүлэх үзэл баримтлалд нийцэхгүй байгааг тэмдэглэж байна.

Сонгуулийн үеийн хууль зүйн зохицуулалтын талаарх харьцуулсан судалгаанаас үзвэл дийлэнх арчилсан улсад ажлын тайлан тараах, сонгогчтой уулзах давуу байдлыг парламентын гишүүнд олгохоос татгалзаж, харин үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд тавих хязгаарлалт нь парламентын гишүүн болон бусад иргэнд тэгш үйлчлэх, парламентын гишүүний давуу байдлыг хязгаарлаж сонгуульд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх чиг хандлагатай байна.

6.3.Сонгуульд оролцох тэгш боломжоор хангах үүднээс аль нэг субъектэд зохих үндэслэлгүйгээр давуу байдал олгохгүй байх нь Үндсэн хуульд нийцнэ. Сонгуулийн сурталчилгааны болон бусад хэм хэмжээ нь Улсын Их Хурлын гишүүн эсэхээс үл хамааран ижил үйл ажиллагаа явуулж байгаа бүх иргэнд болон бүх үед тэгш үйлчлэх, тухайлбал сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэх хүртэлх хугацаанд Улсын Их Хурлын гишүүний сонгогчдод ажлын тайлан тараах, уулзалт хийх боломжийг бусад иргэнтэй адилхан хязгаарлах эсхүл ийм боломжийг Улсын Их Хурлын гишүүн болон бусад иргэнд адилхан эдлүүлэх зэрэг тэнцвэржүүлэх зохицуулалтыг тодорхой хуульчлах нь тохирсон байх, ялгаварлан гадуурхаагүй байх зарчимд нийцнэ. Энэ хүрээнд сонгуульд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бий болгож, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх зэрэг эрх чөлөөг хэн бүхэнд тэгш эдлүүлэх, түүнчлэн Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагааны ил тод байдал, эгэх хариуцлагыг хангахын тулд хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагатай.



6.4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон учир энэхүү дүгнэлт нь гарсан цагасаа хойш (ех пинс) үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай болно (Цэцийн тогтоол, 2024, №02).

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон

### **МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:**

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшиүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг тус тус зөрчсөн байна.

3. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийг Үндсэн хуулийн цэцэд

маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Г.БАЯСГАЛАН**

**ГИШҮҮД**

**Ж.ЭРДЭНЭБУЛГАН**

**Д.ГАНГАБААТАР**

**О.МӨНХСАЙХАН**

**Б.БОЛДБААТАР**



## МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

ГАШУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ,  
НҮҮРСНИЙ ХУДАЛДАА, ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН ХҮЧИН  
ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ  
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН  
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

“Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан тунхаглал”-д үндэслэж,

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар (цаашид хамтад нь “Талууд”, тусад нь “хятадын тал”, “モンゴлын тал” гэх) нь,

Хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгож,

Харилцан ашигтай, эрх тэгш, аж ахуйн нэгжийн манлайллыг дэмжсэн, зах зээлийн үйл ажиллагаа болон олон улсын туршлагад нийцсэн зарчмыг тус тус баримталж,

“Гурвыг цогцоор” зарчимд тулгуурлаж “Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан тэмэр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр хэлэлцэн тохиролцов.

### I. НЭР ТОМЬЁО

(I) Энэхүү хэлэлцээрт дурдсан дараах нэр томьёог доор дурдсанаар ойлгоно:

“Гурвыг цогцоор” гэж Талуудад тогтвортой, урт хугацааны эдийн засгийн үр өгөөжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх “Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан тэмэр замын бүтээн байгуулалтыг хэлнэ. Хоёр улсын аж ахуйн нэгж тус бүр зах зээлийн зарчимд үндэслэн нүүрс худалдаа, худалдан авах урт хугацааны харилцан ашигтай гэрээг байгуулна. Эдгээр гэрээ нь ашигт малтмалын тогтвортой нийлүүлэлтийг хангах зорилгоор Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой цогц арга хэмжээг агуулна.

(II) Энэхүү хэлэлцээрт тусгагдаагүй аливаа нэр томьёог Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу тайлбарлана. Ойлголтын зэрүүтэй заалтыг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

## II. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА

(I) Талууд энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах дараах байгууллагыг тодорхойлов. Үүнд:

Монголын талаас: Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам  
Хятадын талаас: Үндэсний хөгжил, шинэчлэлийн хороо

(II) Төслийн хэрэгжилттэй холбоотой түүхэн нөхцөл байдлыг харгалзан төслийг цаашид саадгүй хэрэгжүүлэх зорилгоор Талуудын холбогдох аж ахуйн нэгжүүд энэхүү Хэлэлцээрийн хүрээнд үйл ажиллагаагаа эрчимжүүлнэ. Холбогдох аж ахуйн нэгжүүдэд доор дурдсан аж ахуйн нэгжийг хэлэх бөгөөд түүгээр хязгаарлахгүй:

Монголын талаас: “Эрдэнэс Тавантолгой” ХК (төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж) болон түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүд байна.

Хятадын талаас: “Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац” (төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж) болон түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүд, эсхүл “Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац”, түүний хамаарал бүхий хуулийн этгээдтэй хамтран ажилладаг хятадын санхүүжилттэй байгууллага, аж ахуйн нэгж байна.

## III. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ, ХҮРЭЭ

Талууд “Гурвыг цогцоор” хамтын ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхийн тулд дараах гурван цогц арга хэмжээг дэмжинэ. Үүнд:

### (I) Хил дамнасан төмөр замыг хамтран барих

1. Талууд “барилгын ажлын нарийвчилсан төлөвлөгөө, стандарт зэрэг холболтын ажлыг хамтран гүйцэтгэх, өөр өөрийн нутаг дэвсгэр дэх төмөр замын санхүүжилтийг талууд өөрсдөө хариуцах, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг зэрэг дуусгах” зарчмыг баримтална. Талууд 2024 оны 4 дугээр сард байгуулсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн дагуу тус тусын нутаг дэвсгэр дээрх төмөр зам, боомтын бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын асуудлыг өөрсдөө хариуцна. Талууд тус тусын төмөр замын царигийн стандарт болон дүрэм, журмыг дагаж мөрднө. Аж ахуйн нэгж хооронд бүтээн байгуулалтын ажлын гэрээнд гарын үсэг зурах, төслийг эхлүүлэх



хугацааны талаар харилцаа холбоог хадгалахад дэмжлэг үзүүлж, бүтээн байгуулалтын ажлыг аль болох эрт эхлүүлэхийг эрмэлзэнэ. Аж ахуйн нэгж хооронд нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ болон Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурах нь хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх урьдач нөхцөл болно.

2. Талууд өөр өөрийн нутаг дэвсгэрт төмөр замын бүтээн байгуулалтын чанарт тавих хяналтыг хариуцах бөгөөд хил холболтын хэсгийн чанарын хяналтыг хамтдаа хариуцна.

3. Талууд энэхүү төмөр замыг хил дамнасан нүүрс тээвэрлэлтэд түлхүү ашиглахыг дэмжиж, хоёр улсын аж ахуйн нэгжүүд хооронд худалдсан нүүрсийг уг төмөр замаар тэргүүн ээлжид тээвэрлэнэ.

### **(II) Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ**

Талууд “Гашуунсухайт-Ганцмод” төмөр зам болон хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт удааширсан, Талуудад учирсан цаг хугацаа болон эдийн засгийн алдагдал, хоёр талын хооронд өмнө нь байгуулж байсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний жишиг зэргийг харгалзан үзэж, харилцан зөвшилцөх замаар хоёр улсын аж ахуйн нэгжүүд “Эрдэнэс Тавантолгой” ХК болон Хятадын төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний хамгийн сүүлд баталгаажсан үнэ (энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах өдрөөс өмнөх) анхны үнэ болгох (FCA-нүүрс нийлүүлэх цэг нь Тавантолгойн уурхайн талбай)-оор тохиролцсон бөгөөд дараагийн үнийг талуудын харилцан зөвшилцэн механизм буюу “анхны үнэ + хамтран сонгож авсан улирлын индексийн тохируулга”-аас гаргана. Нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээнд нүүрсний чанар, хэмжээ, хугацааг тохирч хэлэлцээрт тохирсон үнийн аргачлалыг баримтална.

### **(III) Нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх**

1. Хил дамнасан төмөр замын тээврийн хэмжээ, эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг урт хугацаанд хангах, төмөр замаар тээвэрлэх ачаа тээврийн хэмжээг баталгаажуулах зорилгоор Монголын тал “Эрдэнэс Тавантолгой” ХК Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадал, нүүрс олборлолтын хэмжээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Талууд шинээр уурхайн талбайг хөгжүүлэх, олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд энэхүү гэрээний II зүйлийн (II) дахь хэсэгт заасан аж ахуйн нэгжүүдийг арилжааны зарчмаар оролцохыг дэмжиж, хамтран ажиллана.

2. Эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хүрээнд хайгуул, төлөвлөлт, олборлолтын явцад орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, байгаль орчинд ээлтэй, бүтээмж өндөртэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх нөхцөлийг хангана.

#### IV. ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ

(I) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлснээр “Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа тогтоох тухай Хамтарсан тунхаглал”-ын хүрээнд “Гашуунсухайт-Ганцмод” боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

(II) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хугацаанд, хоёр улсын аж ахуйн нэгж хооронд хэлэлцээрийн үр дүнг хамтын ажиллагааны чиглэл бүрээр дүгнэж, цаашид хамтран хэрэгжүүлэх арга хэмжээг цаг хугацаанд нь төлөвлөнө.

(III) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх хугацаанд, хоёр улсын аж ахуйн нэгж хооронд уг хэлэлцээрийн хүрээнд нүүрс худалдах, худалдах авах урт хугацааны гэрээ шинээр байгуулах нь хоёр улсын аж ахуйн нэгж хооронд өмнө нь байгуулсан нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний биелэлтэд нөлөөлөхгүй.

#### V. БУСАД

Энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш Талууд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын бусад төсөл болон эрчим хүчиний нүүрсний экспортыг идэвхтэй урагшлуулна. Талууд хот байгуулалт, орон сууцжуулалт болон дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. Талууд боомтуудын хамтын ажиллагааг бэхжүүлж, гаалийн нэвтрүүлэх чадавхыг нэмэгдүүлнэ. Талууд аж ахуйн нэгжүүдийг арилжааны зарчмаар сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд үргэлжлүүлэн дэмжинэ.

#### VI. НЭМЭЛТ ЗААЛТ

(I) Талууд өөрсдийн дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангаснаар энэхүү Хэлэлцээр нь хүчин төгөлдөр болох бөгөөд 16 жилийн хугацаанд хүчинтэй байна. Аль нэг тал энэхүү хэлэлцээрийг цуцлах тохиолдолд дипломат шугамаар нөгөө талдаа энэ талаар бичгээр мэдэгдэж, нөгөө талын зөвшөөрлийг авна. Хэлэлцээрийг цуцлах гэж буй тал нөгөө талын зөвшөөрлийг авснаас хойш зургаан сарын дараа



хэлэлцээр цуцлагдана. Хэлэлцээрийг цуцалснаар уг хэлэлцээрийг хүчин төгөлдөр үйлчилж байх хугацаанд хэрэгжүүлсэн хамтын ажиллагаа болон хэлэлцээрийн хүрээнд Талуудын аж ахуйн нэгж хооронд байгуулсан гэрээний үйлчлэлд тус тус нөлөөлөхгүй.

(II) Талууд хооронд хэлэлцүүлж, харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

(III) Талууд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх болон тайлбарлахтай холбоотой аливаа маргааныг найрсгаар харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

(IV) Талууд энэхүү хэлэлцээрийн холбогдох заалтууд болон уг хэлэлцээрийн хүрээнд байгуулсан аж ахуйн нэгж хоорондын гэрээг чандлан биелүүлнэ.

(V) Хэлэлцээрийн хэлэлцээ, үнэлгээ болон хэрэгжилтийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг Талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах бөгөөд нөгөө талаасаа бичгээр урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аливаа нэг гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно. Энэхүү гуравдагч этгээд гэдэгт уг хэлэлцээрийн хүрээнд төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд оролцоогүй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийг ойлгох бөгөөд тэдгээрээр хязгаарлахгүй. Хэлэлцээрийн бусад заалтад нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах эсхүл дуусгавар болгох нь уг нөхцөлийн үйлчлэлд үл нөлөөлнө.

Энэхүү хэлэлцээрийг 2025 оны 2 сарын 14-ний өдөр Харбин хотноо монгол, англи, хятад хэлээр үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна. Ойлголтын зөрүү гарсан тохиолдолд англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЦСӨГЭДСҮРЖИЙН ТУВААН

БОРХҮҮГИЙН ДЭЛГЭРСАЙХАН

БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН  
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ:

ЖӨН ШАНЬЖЕ



**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turiin\_medeel@parliament.mn

**Үтас:** 262420

Хэвлэлийн хуудас: 4.75

**Индекс:** 200003